



**УЛС ТӨР**

**ЗАСГИЙН ГАЗРААС АЛБА, АГЕНТЛАГИЙН УДИРДЛАГУУДЫГ ТОМИЛОО**

**ОНЦЛОХ ХУУДАС**

**БУДЦЫН ШАШНЫ СОЁЛЫН ӨВ СҮЙРЭВ**

II нүүрт

V нүүрт

**МЭДЭЭЛЭЛ**

**ҮЗЭЛ БОДОЛ**

**А.Ганбаатар ЕТГ-ын даргаар томилогдож магадгүй**

**Х.НОРЖИН**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан Ардчилсан намын даргад өрсөлдөх болсноо хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд зарласан. Ардчилсан намд шинэчлэл хийх цаг болсон. Түүний төлөө би зүтгэх болно хэмээж буй түүний эл зоримог шийдвэрийг олон хүн талархан хүлээн авч буй. П.Цагаан даргын шийдвэртэй зэрэгцээд ЕТГ-ын даргын суудалд хэн суух бол гэх таамаг саарал ордноор тэнүүчилж эхэллээ. Ямартай ч, уг албан тушаалд хэд хэдэн хүний нэр яригдаж эхэлсэн байна. Тэдэн дундаас хамгийн магадлал өндөртэй нь эдүгээ Ерөнхийлөгчийн зөвлөхөөр ажиллаж буй Хөлбөмбөгийн холбооны ерөнхийлөгч А.Ганбаатар гэнэ. Тэрбээр сэтгүүлч мэргэжилтэй нэгэн.



Э.ТУУЛ

Өнгөрсөн долоо хоног тэр чигтээ л улс орны эдийн засгийн байдлын эргэн тойронд эдийн засагчид, улстөрчид байр сууриа илэрхийлсээр өнжлөө. Үүний зэрэгцээ аймгийн шинэхэн удирдлагууд хотод ирж, сайд нартайгаа уулзан жаргал зовлонгоо хуваалцсан бол эдийн засагчид чуулж, улс орны эдийн засгийн хүндрэлийг хэрхэн даван туулах гарц байгаа талаар хэлэлцлээ. Улс орны амьдралыг үргэлжлүүлэх шаардлагатай учраас төсвийн тодотгол хийж, түүнийгээ УИХ-ын даргад өргөн барьсан нь ч мөн олны анхаарлын төвд байна. Энэ өдрүүдэд АН-ынхан ч дуугүй суусангүй, ҮЗХ-ныхоо хуралдаандаа бэлдэж, шинэчлэлийн хөдөлгөөн нь өрнөсөөр өнжлөө. Ингээд өнгөрсөн долоо хоногт олны анхаарлыг татсан зарим хүний ярьсныг “Хэн юу хэлэв” булангаараа онцлон хүргэж байна.



Ургэлжлэл нь III нүүрт



Ургэлжлэл нь III нүүрт

**Дугаарын 60 мөр**

**Эрчүүд “ховрын бараа” болох нь**

**Ж.ОТГОНМЯГМАР**

Эрүүлжүүлэхээр өөр эрчүүдэд зориулсан газар алга хэмээн шүүмжилдэг үе байлаа. Одоо харин цаг үе өөр болж, эрчүүдэд зориулсан эмнэлгүүд, дэлгүүр, гоо сайхны газар гээд эмэгтэйчүүдээс дутахааргүй үйлчилгээг авдаг болсон тэд. Өөрөөр хэлбэл, төрөлжсөн эрүүл мэндийн үйлчилгээ авч болох эмнэлэг эмэгтэйчүүдийнх шиг элбэг биш ч гэлээ Монгол Улсын эрчүүдийг эмчлээд байх хэмжээний эмнэлгүүд үйл ажиллагаа явуулж байгаа. Гэтэл сүүлийн үед эрчүүдийн эрүүл мэндийн асуудал аюулын харанга дэлдэж эхлээд байгаа талаар мэдээлэл цацагдах боллоо. Хэдхэн хоногийн өмнө манай улсад болсон “Ази Номхон далайн бүсийн орнуудын эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, насжилт” чуулга уулзалтын үеэр олон ноцтой тоо баримт яригдав.

Ургэлжлэл нь III нүүрт

**УРАН БҮТЭЭЛЧ**

**Т.ЖИНЖИЙМАА: Тамирчин болох минь яав даа гэж харамссан**

**Н.ПУНЦАГБОЛД**

“Хүлэгү” пикчерсийн ээлжит бүтээл “Цагаан хадаг” киноны гол дүрд тоглосон СУИС-ийн жүжигчиний ангийн оюутан Т.Жинжиймаатай ярилцлаа. Энэхүү киног Монгол Улсын Гавьяат тамирчин, Олимпын мөнгө, дэлхийн аваргын хүрэл медальт Д.Сумъяагийн амьдралаас сэдэвлэн бүтээсэн билээ.

дундаа жүдо бөхийн тамирчны амьдрал, замналыг өгүүлж буй гэдэг утгаараа үзэгчдийн сонирхлыг багагүй татаж байх шиг байна. Киноны гол дүрд тоглох боломжийг яаж олж авав? -Анх энэ оны хоёрдугаар сард “Цагаан хадаг” киноны гол дүрийн жүжигчний шалгаруулалт явагдаж байна гэсэн мэдээлэл СУИС даяар тарсан. Тэр үед л намайг ирж шалгаруулалтад орооч гэсэн. Гол дүрийн жүжигчний шалгаруулалт 23 сарын турш үргэлжилсэн юм. Хамгийн анх дуудаж, шалгачихаад дахиад нэг

сарын дараа дуудсан. Түүнийхээ дараа бас сар болоод дуудаж шалгасан. Энэ бүхний эцэст над руу ярьж, шалгаруулалтад тэнцсэн гэдгийг маань хэлж, энэ кинонд тоглохоор болсон доо. Харну хүлээж байх зуураа би жүдогийн шигшээ багийнхантай бэлтгэл хийсэн. Киноныхоо шалгаруулалтад тэнцчих гээд л жүдогийн бэлтгэл хийж байгаа нь тэр шүү дээ. Манай кино багийнхан ч гэсэн “За хэр сайн бэлтгэл хийхээс шалтгаалж чамайг авна” гэж байсан юм.

Ургэлжлэл нь IV нүүрт

**ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА**

**“МАХ ИМПЭКС” МАЛЧДАА ДЭМЖИНЭ**

–Тэд малчдад хэд хэдэн боломжийг санал болгож байна–



**Б.ДАВААХҮҮ**

Монгол Улс гурван сая гаруй хүн амтай. Харин мал сүргийнх нь тоо хамгийн сүүлд гаргасан тоон мэдээллээр 70 саягад давжээ. Үүгээр ч барахгүй сүүлийн таван жилийн статистик судалгаанаас

харахад таван төрөлдөө тасралтгүй өссөн үзүүлэлттэй байгаа юм. Энэ мэдээж сайхан мэдээ. Гэвч малын гаралтай өвчний улмаас гадаадад экспортлох боломж одоогоор хязгаарлагдмал байна.

Ургэлжлэл нь V нүүрт

**ТАЛАРХАЛ**

Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангаас олгох Абуцалтгүй тусламжийн хөрөнгийг Түлэнхийн төвийн барилгыг цогцоор нь барих, тус төвд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хөрөнгө авахад зарцуулахаар Монгол Улсын Засгийн газраас шийдвэрлэсэнд ГССҮТ-ийн хамт олон болон үйлчлүүлэгсдийн нэрийн өмнөөс Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг нарт гүн талархал илэрхийлж байна.

Түлэнхийн эмнэлгийн цогцолбор ашиглалтад орсноор орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологи нэвтрүүлэн түлэгдэл болон яс зөөлөн эдийн хавдар, түлэгдлийн ужиг эмгэгийг оношлох эмчлэх, сэргээн засах тусламж үйлчилгээнд чанар хүртээмж сайжрах чухал ач холбогдолтой юм.

**ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХАМТ ОЛОН**

ХААН банк					Хугалгаа хөгжлийн банк						
	Авах	Зарах	Авах	Зарах		Авах	Зарах	Авах	Зарах		
АМ.ДОЛЛАР	2240.00	2273.00	ФУНТ	2895.00	3034.00	АМ.ДОЛЛАР	2240.00	2273.00	ФУНТ	2932.00	3030.00
ЕВРО	2478.00	2579.00	РУБЛЬ	32.10	37.10	ЕВРО	2496.00	2582.00	РУБЛЬ	33.36	36.49
ИЕН	21.85	22.79	ЮАНЬ	335.00	345.90	ИЕН	22.02	22.86	ЮАНЬ	335.30	345.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

## УЛС ТӨР

## ЗАСГИЙН ГАЗАР

## ЗАСГИЙН ГАЗРААС АЛБА, АГЕНТЛАГИЙН УДИРДЛАГУУДЫГ ТОМИЛЛОО

Ж.ОТГОН

Засгийн газрын ээлжит хуралдаанаар алба, агентлагийн томилгоог хийсэн байна. Тодруулбал, “Эрдэнэс Монгол” компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хэлэлцэн баталжээ. Гишүүдээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Сангийн яамны Төрийн орлогын хэлтсийн дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал гэсэн албан тушаалтнууд томилогдсон байна. Харин хараат бус гурван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар тодруулах ажээ. Хуульд зааснаар ТУЗ-ийн үндсэн гишүүдийн тоо ес хүртэлх байх ёстой бол хараат бус гишүүн нь гурваас доошгүй байна гэсэн заалттай байдаг юм. Харин Тагнуулын ерөнхий газарт /ТЕГ/ бүтцийн өөрчлөлт хийж ТЕГ-ын Тэргүүн дэд даргаар тус газарт Тамгын газрын даргаар ажиллаж байсан н.Донжчимбууг, Дэд даргаар н.Энхсүх нарыг томилжээ. н.Энхсүх нь ТЕГ-г 10 гаруй жил ажиллаж байгаа бол н.Донжчимбуу нь насаараа төрд ажилсан туршлагатай хүн юм байна.

## ШӨХТГ-ын даргаар Б.Лхагвааг томилжээ

Гаалийн ерөнхий газрын дэд даргаар Ё.Бат-Эрдэнийг томилсон байна. Тэрбээр сүүлд Гааль татварын ерөнхий газрын



Гаалийн тариф, татварын газрын даргаар ажиллаж байсан юм. Өмнө нь Улаанбаатар хотын гаалийн газрын дарга, ГЕГ-ын Төв лабораторийн дарга, Замын-Үүдийн гаалийн газрын даргын албыг хашиж байсан хүн юм. Харин шүүхийн шийдвэрийг үндэслэн ШӨХТГ-ын дарга Д.Мөнхтөрийг үүрэгт ажлаас нь чөлөөлжээ. Улмаар Б.Лхагвааг тус газрын даргаар томилжээ. Эргэн сануулахад, 2012 онд О.Магнай ШӨХТГ-ын даргын ажлыг авмагцаа өмнөх дарга Б.Лхагвааг зөвлөлийн таван гишүүнийх нь хамт АТГ шалгуулах хүсэлт гаргаж байсан юм. Учир нь ШӨХТГ нефть импортлогчдыг үгсэн хуйвалдаж шатахууны үнийг литр тутамд 200-300 төгрөгөөр нэмснийг тогтоож, тэднийг нийт 17 тэрбум төгрөгөөр торгох шийдвэр гарсан. Гэтэл ШӨХТГ-ын дарга асан Б.Лхагваа үүрэгт ажлаа авмагцаа энэхүү шийдвэрийг хүчингүй болгосон байдаг юм. Тиймээс тухайн үед шинэ даргаар томилогдсон О.Магнай тэргүүтэй ШӨХТГ-ынхан өмнөх зөвлөлийнхөө зургаан гишүүнийг АТГ-т шалгуулахаар өргөдөл гаргаж байсан удаатай юм. Энэхүү асуудалтай холбоотойгоор өчигдөр үүрэгт ажлаас нь

чөлөөлөгдөхөөр болоод байгаа ШӨХТГ-ын дарга Д.Мөнхтөр “Тавантолгойн шалгалттай холбоотой намйг яаран чөлөөллөө” хэмээн мэдээлэл хийсэн юм. Тэрбээр “Шадаар сайдын зөвлөхүүдийн хэлснээр би аравдугаар сард Хэрэглэгчийн хуулийг батлагдах хүртэл ажиллах ёстой байсан. Гэтэл Тавантолгой компанид шалгалт хийж эхэлсэнтэй холбогдуулж, намйг яаран чөлөөллөө гэж хувьдаа хардаж байна” хэмээн тайлбарлалаа. Тавантолгойн компанид өнгөрсөн долоо хоногийн сүүлээр шалгалт хийж эхэлсэн байна. Шалгалтын явцад худалдан авахтай холбоотой зөрчил гарах магадлалтай байгаа ажээ.

## Түлэнхийн төвийн барилгыг барих санхүүжилтийг шийдэв

Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангаас олгох буцалтгүй тусламжийн хөрөнгийг Түлэнхийн төвийн барилгыг цогцоор нь барих, тус төвд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хөрөнгө авахад зарцуулахаар болсон байна.

Түлэнхийн төвийн барилга нь 1957 онд ашиглалтад орсон бөгөөд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дүгнэлтээр 2009 оноос уг барилгад тусламж үйлчилгээ явуулах боломжгүй болсон юм.

Байргүй болсон учраас Түлэнхийн төвийг “Мөнгөн гүүр” эмнэлэгт түрээсийн гэрээгээр байрлуулж байгаа. Гэтэл цаашид түрээсийн төлбөр төлөх хүндрэлтэй болсон тул одоогоор цөөн хэдэн ортойгоор ГССҮТ-д байрлаж байгаа билээ.

## III цахилгаан станцын хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлнэ

Эрчим хүчний хангамжийн дутагдалд орсон бүс нутгийг эрчим хүчээр хангах, 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангахаар ажиллаж байгаа. Энэхүү ажлын хүрээнд Дулааны III цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар тус тус нэмэгдүүлэх төслийг эхлүүлэхээр болжээ. Шаардлагатай санхүүжилтийг

шийдвэрлэхийг Засгийн газрын тогтоолоор холбогдох сайд нарт үүрэг болгосон байна.

## Автозамын төслүүдийг хянах ажлын хэсэг байгууллаа

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат автозамын салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээгээр хэрэгжүүлсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулсан байна. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтаар автозамын 30 төсөл баталсан. Уг жагсаалтад барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжих 27, барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжих гурван төсөл байгаа аж. Тодруулбал, барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжих 27 төслөөс улсын комисст хүлээлгэн өгсөн хоёр, гэрээ хүчин төгөлдөр болж барилгын ажил явж буй долоо, гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа нь болоогүй дөрөв, концессын гэрээ байгуулаагүй хоёр, тогтоолалбажаагүй хоёр, барих-ашиглах-шилжүүлэх эрхтэй гурав, ажил эхлээгүй долоон

төсөл байгаа юм байна. Тиймээс автозамын салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээгээр хэрэгжүүлсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийх, төслүүд улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцсэн эсэх талаар дүгнэлт гаргахаар болжээ. Түүнчлэн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалтай уялдуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат холбогдох яам, газруудын төлөөллийг оролцуулан байгуулж, үр дүнг нь энэ оны дөрөвдүгээр улиралд багтаан танилцуулахаар болжээ.

Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга Г.Отгонбаяр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн асуудлын талаар мэдээлэл хийсний дараа сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулсан юм.

## -Гурван дэд сайдыг яагаад томилоогүй юм бэ?

“Өчигдрийн хуралдаанаар буюу ажлын цаг дуусах үед АТГ-аас 10 хүний ашиг сонирхлын зөрчилтэй эсэх лавлагааг ирүүлсэн байсныг хэлэлцсэн. Үлдсэн гурван сайдын лавлагааг АТГ-аас ирүүлэх үү, ирүүлж амжаагүй юу гэдгийг Засгийн газар мэдэхгүй байна.

## -Ипотекний зээл цаашид үргэлжлэх үү?

Ипотекний зээлийг иргэдэд илүү хүртээмжтэй болгохыг судалж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайдад даалгасан.

## МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## АН хагаралтай болсон нь удирдлага, фракциудын явуулга гэв

АН-ын ууган гишүүд болон АН-ын нэгдсэн намуудын ахмадууд мэдээлэл хийлээ. Тэд “АН энэ ондоо багтаан их хуралдайгаа хийж, намын удирдлагуудаа нээлттэйгээр сонгох учиртай. Ингэж байж намын цаашидын бодлого, мөрийн хөтөлбөрүүдээ батлаад явах ёстой” гэлээ. Түүнчлэн АН-ын үндэсний зөвлөлдөх хороо яаралтай хуралдаж, намын үндсэн дүрэм, шинэ үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсгийг намын нийт ахмад, залуу гишүүд, улс төр судлаачдыг оролцуулж байгуулахыг шаардлаа. Мөн намын их хурал зохион байгуулах ажлын хэсгийг намын дэргэдэх байгууллага анхан шатны нам, үүр, намаа шинэчлэх хөдөлгөөний төлөөллийг тэгш оролцуулан бүрдүүлэх ёстойг хэмээлээ. АН 2016 оны ээлжит сонгуульд ялагдахаас гадна толгойгүй, замбараагүй, хагаралтай болсон нь тус намын удирдлага, фракциудын явуулга гэж ахмад гишүүд тодорхойлж байгаа аж. Иймээс тэд зургаан жил намынхаа их хуралдайг хийгээгүй, намдаа ардчиллын салхи оруулаагүй дотроо дайтсан ардчиллыг зогсоохыг хүсч байгаа гэнэ. АН хэдхэн фракцын толгойлогчдын мөнгө олох, албан тушаал, эрх мэдэл наймалцах хэрэгсэл болсонд шүүмжлэлтэй хандаж байгаагаа дуулгалаа.

## АН-ынхан ҮЗХ-ны хурлаа хойшлууллаа

Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооны хурал өчигдөр 14.00 цагт эхлэх тов гарсан байсан. Энэхүү хурлаар намын дүрэм, тогтолцоог шинэчлэх ҮЗХ-ны гишүүдийн тоог нэмэх, зарим гишүүдийг ҮЗХ-ноос чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх байсан. Тодруулбал, Н.Алтанхуягийн Засгийн газрыг огцруулахад гар бие оролцсон гишүүдийг намын дүрмийн дагуу ҮЗХ-оос хасч магадгүй гэсэн мэдээлэл байгаа. Мөн намын даргын асуудлыг ярих ёстой. Гэвч АН-ын Хэрэг эрхлэх газрын мэдээлж буйгаар

## ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

## УИХ-ЫН ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫГ НЭЭЛЭЭ

УИХ-ын ээлжит бус чуулганыг нээлээ. Энэ удаагийн чуулганаар 23 багц асуудлыг хэлэлцэх юм. Чуулганыг нээж УИХ-ын дарга М.Энхболд хэлсэн үгэндээ “Улс орны нийгэм, эдийн засаг, төсөв, санхүүгийн нөхцөл байдал хүнд, хямралын шинжтэй байна. Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд тасралтгүй унаж, эдийн засгийн өсөлт оны эцэст 1,3 хувьтай гарахаар байгаа. Төлбөрийн балансын алдагдал нэмэгдэж, гадаадын хөрөнгө оруулалт огцом буурч, төгрөгийн ханш тасралтгүй суларч, хүн амын худалдан авах чадвар буурсаар байна. Нэгдсэн төсвийн орлого сүүлийн жилүүдэд нэг их наяд гаруй төгрөгөөр тасарч, жил бүр 2-3 удаа тодотгол хийж ирсэн. Монгол Улсын нэгдсэн төсөв дөрвөн жил дараалан их хэмжээний алдагдалтай гарч байгаа нь төсөв санхүүгийн алдаатай бодлого, татвар төлөгчдийн мөнгөний үр ашгийг, үрлэгэн зарлагдаж ирсэнтэй шууд холбоотой. 2016 оны

“Ард иргэдийн ахуй амьдралд ноцтой нөлөөлөх олон шийдвэр гаргахаар УИХ-ын ээлжит бус чуулган хуралдах гэж байна. Иймд наймдугаар сарын 25-нд болох АН-ын ҮЗХ тодорхойгүй хугацаагаар хойшлилоо. Ардчилсан намын Хэрэг эрхлэх газар” гэжээ. Тиймээс хөдөө орон нутгаас ҮЗХ-д оролцохоор нийслэлд ирсэн гишүүд зорилгоо биелүүлэхгүй буцах нь болжээ. Хэрвээ ҮЗХ-ны хурлаа ээлжит бус чуулгантай давхцуулахгүй гэвэл ирэх сарын 15-ныг хүртэл хуралдахгүй бололтой.



долдугаар сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн алдагдал 1.9 их наяд төгрөг хүрчээ. Бодит байдал дээр улсын эдийн засаг, санхүүгийн байдал төсөөлж байснаас хэд дахин хүнд байгааг Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан мэдээллээс амархан дүгнэж болохоор байна. Нийгэм эдийн засгийн үзүүлэлт олон улсын төвшингээс буурсаар байгаа юм. Нөхцөл байдал ийм болсныг олон улсын байгууллага дүгнэж хэлсэн тул бид талцах

биш хямралыг хохирол багатайгаар даван туулах, санхүү эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах нь амин чухал асуудал болоод байна” гэв. Ийнхүү өчигдөр ээлжит бус чуулган нээлтээ хийгээд өнөөдөр 10:00 цагт хуралдахаар тов зарлалаа. Чуулганы хуралдааны дараа хэлэлцэх асуудалтай холбогдуулж МАН-ын бүлэг Төрийн ордны “А” танхимд, АН-ын бүлэг Төрийн ордны “Б” танхимд богино

хугацаанд хуралдсан. Өмнө нь намын бүлгүүд хэлэлцсэн асуудалтайгаа холбогдуулж мэдээлэл хийдэг байсан. Харин энэ удаад хэвлэлийнхэнд мэдээлэл өгсөнгүй. Эх сурвалжийн мэдээлж буйгаар МАН-ын бүлгийнхэн төсвийн тодотголд хяналт тавих ажлын хэсэг, мөрийн хөтөлбөрөө харууцах ажлын хэсэг байгуулах тухай ярилцжээ. Харин АН-ын бүлэг төсвийн тодотголыг авч хэлэлцсэн байна.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчлалыг алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

## Эрчүүд “ховрын бараа” болох нь

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Эрүүл мэнддээ анхаардаггүй буюу өвдсөнөө ч тоохгүй, идэж, уухаа хязгаарлахгүй, таргалалтаа хянахгүй яваад байвал Монгол Улсын жендерийн харилцаа алдагдах гэнэ. Энэ асуудал үндэсний аюулгүй байдлын асуудал болон хөндөгдөх хэмжээнд хүрч болзошгүй гэдгийг мэргэжилтнүүд ч сануулж байна.

Хамгийн гол нь монгол эрчүүд маань архи тамхины хэт хамааралтай байгаагаас зүрх судас, даралт ихсэх, хавдрын өвчлөлд хамгийн их өртөж байгаа аж. Тодруулбал, хоёр эрэгтэй тугмын нэг нь тамхи татдаг, мөн хоёр эрэгтэй тугмын нэг нь архи хэтрүүлэн хэрэглэдэг муу зуршилтай учир монгол эрэгтэйчүүд дэлхийн бусад орны эрэгтэйчүүдээс 10-15 жилээр бага наслаж байгаа гэнэ. Харин монгол эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75 байхад эрэгтэйчүүдийн дундаж насжилт 66 байгаа гэсэн тоо баримт байна. 2015 оны эрүүл мэндийн статистикийн үзүүлэлтээр эрэгтэйчүүдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгалын замын, хоол боловсруулах тогтолцооны, бэлгийн тогтолцооны өвчин, зүрх судасны өвчин, гэмтэл, хордлого буюу гадны шалтгаант эмгэг орсон байна. Эдгээрээс хамгийн хүндэрсэн үедээ эмнэлгийг зорин ирдэг өвчлөлд бэлгийн замын өвчлөл буюу үргүйдэл, түрүү булчирхайн өвчлөл орсон байгаа юм. Ийнхүү өвчнөө хүндрүүлсэн нь үргүйдэл ихсэх хамгийн том шалтгаан болсоор байгаа аж. Тухайлбал, манай улсын үргүйдлийн 40 хувийг эрчүүд эзэлж байна. Мэдээж шалтгаан нь даавар, удамшил, БЗХӨ, хавдарт өвчлөлдүүл бол эмнэлэгт оч. Эрүүл мэнддээ анхаарах шаардлагатай байна. Архи, тамхины хэрэглээг багасгаж, хоол хүнсэндээ жимс, ногоо түлхүү хэрэглэж, дасгал хөдөлгөөн хийгээд байж яагаад болохгүй гэж. Өргүй бол баян, өвчингүй бол жаргал биз дээ. Цаг үетэйгээ хөл нийлүүлэх цаг нь иржээ эрчүүд ээ. Тэгээд ч эцэстээ эрчүүд минь ховрын бараа болж, эмэгтэйчүүдийн улс болчихвол яана. Үргүйдэл гэдэг гамшиг үргэлжилсээр байгаад улс орон минь мөхөхдөө тулвал яана. Тиймээс одоо хожимдоогүй дээрээ арга хэмжээ авч, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлж, болж өгвөл хорт зуршлаасаа салчихвал өвчин хийсч ирж ч чадахгүй шүү дээ.

мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад бүхий л хүч чадлаа зориулан ажиллаж ирлээ. Эдүгээ Ерөнхийлөгчийн Тамгын газар хамгийн тогтвортой, тасралтгүй, гацаагүй, хүнд сурталгүй үйл ажиллагаатай институци болж төлөвшсөн бөгөөд чадварлаг залуу хамт олноос бүрдэж байна. Цаашид ч энэ эрч хүчээрээ ажиллана гэдэгт би бүрэн итгэлтэй байна. Энэ жил гэхэд л үндэсний түүх, соёлтой холбоотой арга хэмжээ болон АСЕМ, Олон улсын монголч эрдэмтний их хурал гээд олон ажлыг амжилттай зохион байгуулсныг та бүхэн сайн мэдэж байгаа. Өнөөдөр би та бүхэнд Ерөнхийлөгчийн болон ЕТГ-ын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар биш, өөрийн гаргасан улс төрийн шийдвэрийн талаар мэдээлэл хийхээр урьсан юм. Өнөөдөр Монголын нийгэмд хуримтлагдсан олон асуудлыг шийдвэрлэх, Монголын ирээдүйг тодорхойлоход Ардчилсан намын хүлээх түрхэн үүрэг их билээ. Өнөөгийн Монголын нийгэмд тулгарсан хүндрэл бэрхшээл, сорилт бол засаглалын чадавх сул, улс төрийн намуудын төлөвшлөөс улбаатай гэж үзэж байгаа. Монголын ард түмэн ардчиллыг, АН-ыг байнга дэмжиж, ихийг хүлээдэг. Харамсалтай нь тэр итгэлийг манай нам дааж чадахгүй байна. Энэ нь намаа олон фракцид хуваасан, дүрмээ мөрддөггүй, боловсон хүчний зөв бодлого баримталж чадаагүй гээд олон шалтгаантай та бүхэн мэдэж байгаа байх. Өнөөдөр АН-ыг тогтсон

Ардчилсан намыг шинэ үе удирдах цаг нь болсон. Ардчиллын төлөө анх тэмцэж байсан гэдгээрээ бамбай хийж өөрсдийгөө хамгаалж, эрх мэдлийг, эрх ашгийг хувааж авдаг энэ тэмцлээ болих хэрэгтэй. Тэгэхгүйгээр Ардчилсан нам цаашаа явахгүй. Энэ чинь улс төрийн нам. Амьд харилцаа, үе солигдолт зайлшгүй хийгдэх ёстой. Ямар ч байсан шинэчлэл хэрэгтэй. Харьж яваа хүн ирж яваа цагийн дууг дуулдаггүй гэж би өмнө нь хэлж байсан. Одоо ч хэлнэ. Тэгэхгүйгээр Ардчилсан намын далбаан дор цөөн хэдэн фракцийн тэргүүнүүд өөр өөрсдийн ашиг сонирхлоор намыг ч, улсыг ч удирдаад байж болохгүй. Цаг үе гэдэг өөрийн дүрэмтэй, хуультай. Үүнийг ойлгохгүйгээр намын шинэчлэлийг зогсоох гэж оролдовол бид нар нэгдэнэ. Хамтарч ажиллана. Процесс, яриа үргэлжилж байна. Би одоо үргэлжлүүлээд уулзалтад орно. Ямар ч байсан намын ерөнхий нарийн бичгийн даргад УИХ-ын гишүүн асан М.Батчимэгийг нэр дэвшүүлэхээр ярьсан. Харин Ардчилсан намын даргад хараахан шийдээгүй байна. УИХ-ын гишүүн Лу.Гантөмөрийн тухайд өнөөдөр нэр дэвшихгүй. Эрх мэдэл, мөнгө хоёр хардаг хүний хувьд өнөөдөр Ардчилсан нам бол үнэхээр хоосон ёроолоо эргүүлж харуулаад гөвчихсөн шуудай л харагдаж байгаа. Одоо гол нь зөвхөн мөнгө, эрх мэдэл ярьдаг хүмүүсийн дуу хоолой Ардчилсан намд алга болно. Ийм үед эрүүл сэтгэлгээгээр эрүүл саруул зүйл ярьдаг хүмүүсийн дуу хоолой тодорч сонсогдох боломжтой. “Их захгүй бөмбөр балбаж байхад пипи хөгжмийн дуу сонсогддоггүй” гэж Энэтхэгийн их гоё үг байдаг. Түүнтэй адилхан мөнгө, эрх мэдлийн төлөө алалцаж байхад нөгөө талд нь хүний эрх, шударга ёсны дуу хоолой сонсогддоггүй юм билээ. Өнгөрсөн дөрвөн жил тийм л байсан. Одоо мөнгө, эрх мэдэл хоёр нь байхгүй байгаа үед тэр бүхний төлөө чанга дуугарч, цэжэээ балбадаг хүмүүс бараг Монгол ардын намын гишүүнчлэлээ сэргээх нь ашигтай гэж бодож байх мэднэ. Яг ийм үед л зоригтой шинэчлэл хийх хэрэгтэй. Гэхдээ зарим нэг хүмүүс нам доторх нөлөөгөө хадгалж үлдэхийн тулд үлгэрийн баатар амилна гэдэг шиг дөрвөн жилийн дараа би дахиад л амилна гэсэн зорилгоор асуудалд хандахыг үгүйсгэхгүй” хэмээжээ.

### П.Баттогтох: Тариалангийн бүс нутгаар цочир хүйтэрнэ

*/ОБЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа/*

-ОБЕГ-аас хадлан бэлчээр, өвөлжилтийн бэлтгэл ажил, цаг уурын нөхцөл байдал болон бусад асуудлаар мэдээлэл хийсэн. Энэ үеэр ОБЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа П.Баттогтох “Энэ жил бороо хур элбэгтэй байгаа боловч газар тариалангийн бүс нутагт ургац, хадлан авах хугацаа оройтож, тариа болон хүнсний ногооны болц оройтож болзошгүй байна. Үүнтэй холбоотой ХАА-н бүсүүд дараах арга хэмжээг авах шаардлагатай байгааг анхааруулж байна. Газар тариалангийн бүс нутгийн хувьд наймдугаар сарын сүүлийн арван хоног болон есдүгээр сарын дунд үеэс цочир хүйтэрч хяруу унах төлөвтэй байгаа учраас хяруунаас хамгаалах зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулах, тариа будааг цасанд даруулахгүйн тулд зохистой арга хэмжээг авч, ангилан хадгах үйл ажиллагааг цаг тухайд нь хийх шаардлагатай байна. Ийм учраас орон нутаг, аймаг сумдын онцгой байдлын комисс техник хангамж, хүч хэрэглэлийнхээ тооцоо судалгааг гаргах арга хэмжээ авах хэрэгтэйг анхааруулж байна” гэв. Мөн ОХУ-ын Алтайн хязгаар, Тувагийн Бүгд Найрамдах Улс, Эрхүү зэрэг газруудад цочир хүйтрэх, үер усны аюул гарах, зарим газруудаар гантай байх төлөвтэй байна. Үүнтэй холбогдуулан есөөс арван сард үргэлжлэн ой хээрийн түймэр гарч болзошгүй учраас тус бүс нутгаас эрчим хүчний хувьд хараат байдаг баруун аймгууд саатал доголдол гарах үед бэлтгэлтэй байж, урьдчилсан ажиллагааны төлөвлөгөөг тодотгоход анхаарч ажиллахыг ОБЕГ-аас зөвлөлөө. Түүнчлэн тэрбээр “Монгол орны зуншлагын төлөв байдлыг 2016 оны наймдугаар сарын 20-ны өдрийн байдлаар гаргахад нийт нутаг дэвсгэрийн 60 орчим хувь нь сайн, 35 орчим хувь нь гандуу, 5 хүрэхгүй хувь нь гантай байна. Аймгийн дүнгээр авч үзвэл Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай зэрэг 15 аймгийн 47 сумын нутагт бэлчээрийн даац онцгой хэтэрсэн бөгөөд мал өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүй тул иргэд дулаан хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнсний нөөцийг эртнээс бэлтгэх, бэлчээрийн даацад тохирсон малыг өвөлжүүлэх, гэр орон, малын хашаа хороо, байр сууцны дулаалга, нөмөр хаалтыг хийх, засч сэлбэх хэрэгтэй” хэмээн анхаарууллаа.

үзэл баримтлалтай, тогтвортой бүтэцтэй, судалгаанд суурилсан хөгжлийн бодлоготой, цэгцтэй боловсон хүчний бодлоготой, улстөрийн өрсөлдөөний шинэ соёлтой, нээлттэй, өрсөлдөх чадвартай улс төрийн хүчин болгох шаардлага, АН-ыг ардчиллын суурь үнэт зүйлсийг мэддэг дээдэлдэг, эрхэмлэдэг залуу үеийнхнээр бэхжүүлэхийг цаг үе шаардаж байна. Энэхүү шинэтгэл, шилжилтийн хариуцлагатай, эгзэгтэй цаг үед миний бие ямагт үндэснийхээ эрх ашгийг дээдэлж, АН-аа нэг цул байх ёстой гэж үзэж ирсэн байр сууриа дахин нотолж, хуримтлуулсан төрийн болон улстөрийн ажлын туршлага, эдийн засаг, улстөр, хууль цааз, гадаад харилцааны мэдлэг боловсролоо Ардчилсан намынхаа шинэтгэлийн үйлсэд зориулах нь зүйтэй гэж шийдсэнээ та бүхэнд мэдэгдэж байна. Аливаа шинэтгэлийг уг шинэтгэлийн зайлшгүй ойлгосон, мэдэрсэн, бас хэрэгжүүлэх чин хүсэл эрмэлзэлтэй хүмүүс л хийдгийг би мэднэ. Энэ амаргүй үйл хэргийг манлайлж, хатаагдсан ахмад үе, ид жагсаж яваа дунд үе, ихийг бүтээх өрнүүн эрмэлзлэлтэй залуу үеийнхний холбоос, гагнаас, гүүр нь болон хамтран ажиллаж, зохион байгуулж хүссэн үр дүнд хүргэж чадна гэдэгтээ итгэлтэй байна” гэлээ.

### Х.Тэмүүжин: Яг ийм үед л зоригтой шинэчлэл хийх хэрэгтэй

*/УИХ-ын гишүүн, Хууль зүйн сайд асан/*

-АН-ын Үндэсний зөвлөлдөх хороо энэ сарын 25-нд хуралдах байсан ч тодорхойгүй хугацаагаар хойшилсон. Үүнтэй холбогдуулан УИХ-ын гишүүн, Хууль зүйн сайд асан Х.Тэмүүжин ярилцлага өгчээ. Тэрбээр “ҮЗХ хуралдах өдөр бол товчхондоо, шинэчлэлийн хаалгаа зөв нээх үү, үгүй гэдэг өдөр. Өнөөдөр зөв нээж чадал Ардчилсан нам цаашаагаа алхана. Харин буруу алхвал Ардчилсан нам ахиад л 1996-2000 онд бужигнаж бужигначихаад хуучин төрхөндөө эргэж буусан тэр л дүр зурган дээрээ очино. Киног ухрааж үзэж байгаагай л адилхан үзэгдэл болно. Нам дахиад л бужигнана. Нам гэдэг чинь амьд процесс. Би хувьдаа нүдэлцээд л дуусах байх даа. Гол нь Ардчилсан нам нээлттэй болж, өөрчлөгдөж, шинэчлэгдэх ёстой гэдэг бол зүй ёсны үзэгдэл. Тэр дундаа, УИХ-ын сонгуулиар ард түмний итгэлийг авч чадаагүй улс төрийн намд шинэчлэл зүй ёсоор хийгдэх ёстой. Энэ бол хэвийн үзэгдэл. Ийм эрүүл үзэгдлийг үгүйсгэж болохгүй. Тэр дундаа шинэ үеэ хүлээн зөвшөөрөхөөс илүүтэй хэн нэгний далбаанд нааж боддог энэ хэв маягийг бид өөрчлөх хэрэгтэй байна. Би энэ саналаа илэрхийлнэ. Өнөөдөр

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

### Д.Эрдэнэбат: Сангийн сайд гоншигнолгүй ажлаа хий

*/УИХ-ын гишүүн/*

-Төсвийн тодотголтой холбоотой өөрчлөлтүүдийг би дөнгөж аваад байна. Нөхцөл байдал эвгүй тавигджээ гэж харсан. Төсөв алдагдалтай байгаа нь ойлгомжтой. Уул уурхайгаас хамаарсан эдийн засгийн уналт дөрвөн жил үргэлжилсэн нь үнэн. Эдийн засгийн хүндрэл бол АН-ын, МАН-ын гэж байхгүй, ард түмний эрх ашигтай холбоотой зүйл. Тиймээс үүнд улстөржиж, намынхаа явцуу эрх ашгийг бодооч гэдгийг би байнга хэлж байгаа. Өнөөдрийн орж ирж байгаа төсөв бол дэндүү хариуцлагагүй байна. Эдийн засгийн хүндрэлтэй энэ үед төсвийн алдагдлыг ард түмний халааснаас нөхнө гэдэг бол дэндүү хариуцлагагүй үйлдэл. Та бүхэн хараарай. Орж ирсэн төсөв зөвхөн иргэдийн цалин, тэтгэмж, шимтгэл, эзэмшиж байгаа хөрөнгөтэй холбоотой бүх зүйлээс татвар авна гэж байгаа. Энэ бол туйлын хариуцлагагүй бөгөөд харгис үйлдэл болж байна. Ард түмнийг ингэж хуурч болохгүй. 1000 ам.долларын цалин өнөөдөр амжиргааны л түвшин

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

шүү дээ. 1000 ам.долларын цалинг Монгол тун цөхөн хүн авч байгаа. Гэхдээ хүнд, оюуны хөдөлмөр хийж байгаа хүмүүс авч байгаа. Зарим төрийн өндөр албан тушаалтай хүмүүс авч байгаа байх. Өөр хэн авч байгаа юм. Өнөөдөр 1000 ам.доллар бол амьдралын дундаж хэрэглээ. Үүнийг их мөнгө гэж үзэж байвал дэндүү хариуцлага үйлдэл. 1000 ам.долларыг өндөр цалин гэж үзээд 25 хувийн босготой татвар авна гэдэг бол ямар ч тооцоогүй үйлдэл байхгүй юу. Над руу маш олон иргэд хандаж байна. Үл хөдлөх хөрөнгийн татвар гэдэг аймшигтай юм тавьж байна. 500 квм байртай хүн жилд 18 сая төгрөг төлнө гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Би шүүмжлэхийн тулд шүүмжилж байгаа юм биш. Бид асуудалд нухацтай хандах ёстой. АН байр сууриа илэрхийлэх ёстой. Хоёр хуульд хамгийн их эмзэглэж байна. Нэг нь Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль. Есдүгээр сарын нэгнээс үйлчлэх ёстой байсан. Хөнгөхөн, жижигхэн шалтгаанаар энэ хуулийг хойшлуулж байгаа нь хариуцлагагүй үйлдэл. Хуулийн хугацааг хойшлуулах ноцтой шалтгаан угаасаа байхгүй. Олон олон гэр бүл хуулийн үйлчлэх хугацааг хүлээж байгаа. Төрийн шийдвэр уламжлагдаад явах ёстой. Хоёр дахь нь Хамтын тэтгэврийн тухай хууль. Энэ хуулийг хүчингүй болгож оруулж ирж байгаа нь бас хариуцлагагүй үйлдэл. Хамтын тэтгэврийн хуулийн гарах зардал нь тун бага. Хамгийн гол нь Сангийн сайд улстөржих хэрэггүй, Сангийн сайдын ажлаа хийх ёстой. Ардын намын Сангийн сайдын ажил нэг өөр байгаагүй. Бид нэг л ижил зовлон туулж байгаа, гоншигнолгүй ажлаа хий. Тэгж ярих юм бол өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд МАН ч бидэнтэй хамтарч, Засгийн газар барьсан. Өнөөдрийн Ерөнхий сайд Сангийн сайд байсан. Гэнэт ийм зүйл руу орсон гэж уулга алдах хэрэггүй. Нөхцөл байдал ийм байсныг бүгдээрээ сайн мэдэж байгаа.

### П.Цагаан: Туршлагаа АН-ын шинэчлэлд зориулна

*/Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга/*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимдхэвлэлийн бага хурал зарлаж, Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын албан тушаалаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, Ардчилсан намын шинэчлэлийн төлөө гар бие оролцохоор шийдсэн гэдгээ зарлалаа. Тэрбээр “Миний бие 2009 оноос хойш өнөөг хүртэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн Дэд бүтэц, эрдэс баялаг, Хуулийн зөвлөх, Цэрэг, Аюулгүй байдлын зөвлөх, ахлах зөвлөх, Тамгын газрын даргаар ажиллаж, Монгол Улсын Төрийн тэргүүний гадаад, дотоод бодлого, үйл ажиллагааны

ASUS ROG G-SERIES

REPUBLIC OF GAMERS

NVIDIA GeForce GTX

Intel Core i7

ALBAN ESOOP PC mall - Д ИРЛЭЭ

## ЭНТЕРТАЙНМЭНТ

## УРАН БҮТЭЭЛЧ

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Тэгэхээр нь “Намайг чавчихаагүй юм байна” гээд л бэлтгэлээ хийгээд байлаа. Бараг 10-аад хоног жүдогийн шигшээ багийнхантай хамт бэлтгэл хийсэн. Бэлтгэл хийх хугацаандаа би өөрийгөө эвсэл сайтай юм байна гэж бодсон шүү. Гэхдээ л жүдо бөхөөр хичээллэнэ гэдэг үнэхээр хэцүү юм билээ. Тэр дундаа эмэгтэй хүн барилдана гэхээр хэцүү санагдсан. Тэгэхдээ кинодоо тоглохын тулд хичээж, бэлтгэлээ хийсэн. Улмаар тавдугаар сарын 26-нд анхны мотор дуугарч, зургандаа гарсан даа.

Энэ киногоор жүдо бөхийн тамирчны амьдралыг харуулах гэж байгааг хүмүүс мэдэж байгаа. Гэхдээ яг ямархуу үйл явдлууд гарах бол гэж хүлээж байгаа байх. Зах зухаас нь жаахан цухуйлгавал?

“Би эхэндээ энэ киноны талаар сонсоод барилдаад л байдаг охины тухай гарах юм байна гэж бодсон. Харин киноныхоо зохиолыг уншихад миний төсөөлж байснаас огт өөр байсан. Зөвхөн барилдах биш. Энэ кинонд Даваа гэдэг тамирчин охины амьдрал 10 наснаас нь эхлээд л гарах юм. Багадаа ямар орчинд өссөн. Бөхийн спорттой хэрхэн холбогдсон.

байсан. Тийм болохоор л би маш их айж байлаа. Жүдогийнхонтой бэлтгэл хийж байхад тамирчид намайг эвсэлтэй байна гэж байсан. Хэдийгээр тийм ч Олимпын наадамд түрүүлж байгаа тамирчны барилдааны ур чадварыг харуулж чадахгүй байх гэж их айсан. Гэхдээ л би хамаг чадлаараа хичээсэн. Энэ кинонд жүжигчний чадварыг сорьсон нэлээд олон хэсэг гардаг. Тэр болгоныг ямар ч байсан давсан. Миний хувьд маш том сорилт байсан л гэж хэлмээр байна.

Гавьяат тамирчин Д.Сумъяагийн амьдралаас сэдэвлэсэн кино гэж яриад байгаа. Үнэхээр эхнээсээ л энэ хүний амьдралаас сэдэвлэсэн байсан юм уу. Эсвэл жүдогийн спортын тухай кино хийж байгаад Д.Сумъяаг Олимпын медаль авчихаар менежмент хийчихэв үү гэдэг хардлага бас гарч ирээд байна?

“Сошиал ертөнцөөр “Д.Сумъяа Олимпын наадмаас мөнгөн медаль авчихаар түүний амьдралаас сэдэвлэсэн гээд байна” гэсэн яриа их гарч байгаа. Аль нэгдүгээр сард жүдогийн тамирчны амьдралаас сэдэвлэж байгаа гэж ярьж байсан. Зураг авалт эхлэхээс өмнө би хоёрдугаар найруулагчаасаа “Хүний тухай өгүүлэх кино юм

Ярилцсаны эцэст Д.Сумъяагийн амьдралаар кино хийхээр сонгосон юм билээ.

Энэ кинонд тоглохоор болсныхоо дараа Гавьяат тамирчин Д.Сумъяатай уулзаж, судалгаа хийсэн биз дээ. Тэр хүнээс ямар өгөгдөл авсан бэ?

“Д.Сумъяа эгчтэй хэд хэдэн удаа уулзаж, бэлтгэл хийсэн. Надад өөрийнхөө үндсэн мэх болох үүрэг зааж өгч байлаа. Ер нь хүмүүс Д.Сумъяа эгч бид хоёрыг машадилхан гээд байгаа. Хараад байхад байгаа байдал, зан ааш, гаргаж буй сэтгэлийн хөдлөлөлтөд нэгдэн хамт байхад байгаа байдал, зан ааш, гаргаж буй сэтгэлийн хөдлөлөлтөд нэгдэн хамт байхад байгаа болох. Би энд нэг зүйлийг хэлэхийг хүсч байна. Д.Сумъяа эгчийн овог нэр нь Доржсүрэнгийн Сумъяа. Би энэ кинонд Доржсүрэнгийн Даваа гэдэг нэртэй тамирчны дүрд тоглосон. Сумъяа гэдэг чинь нэг дэх өдөр биз дээ. Даваа гэдэг чинь ч бас нэг дэх өдөр. Энэ бол эхнээсээ л бодож, төлөвлөж өгсөн нэр. Үүнийг ч хүмүүс анзаарах хэрэгтэй. Тэгэхгүй Д.Сумъяагаар менежмент хийлээ гээд яриад байгаа нь буруу. Би зориуд хэлмээр санагддаг байна.

Орлон тоглогчоор жүдо бөхөөр хичээллэдэг тамирчин охиныг авсан байсан. Зарим мэхний

# Т.ЖИНЖИЙМАА: ТАМИРЧИН БОЛОХ МИНЬ ЯАВАА ГЭЖ ХАРАМСАН

Тэр үед эцэг, эх нь хэрхэн хандсан, ямар шалгуурыг давсан гээд олон зүйлийг өгүүлнэ. Хамгийн гол нь тэр хүн ямар хэцүү зүйлийг даван туулж байж амжилтад хүрсэн бэ гэдгийг харуулах юм.

Өөрийн чинь тоглосон анхны кино гэсэн. Хэдийгээр мэргэжлийн сургуульд суралцаж, номыг нь үзэж, “ногоотой шөл”-ийг нь ууж байгаа ч яг камерын өмнө гараад жүжиглэх бол өөр байх нь тодорхой. Хүндрэлтэй, хэцүү зүйл хэр тохиолдов?

“Би өөрийгөө үнэхээр азтай охин гэж боддог. Яагаад гэвэл маш том кино групп, үнэхээр чадварлаг найруулагчтай оюутан байхдаа хамтарч ажиллалаа. Дээрээс нь Монголын алдартай тамирчны амьдралаас сэдэвлэж хийж байгаа кинонд тоглох том боломж надад олдсонд баярлахгүй байхын аргагүй. Анхны уран бүтээлийн гараагаа ингэж эхэлсэн нь цаашдын миний зам мөрийг ерөөж өгсөн гэж боддог. Энэ кинонд 10 мянган хүний масс гарна. Тэр олон хүн миний төлөө орилж байгаа юм шиг санагдаад, яг өөрөө алтан медаль авчихсан юм шиг, Олимпын аварга болчихов уу гэмээр огшдог юм билээ. Мэдээж би дөнгөж анхны уран бүтээлдээ оролцож байгаа. Тийм болохоор мэдээж айж байсан. Хүмүүс намайг энэ киноны гол дүрд тоглуулахаар сонгосондоо харамсах вий дээ гэж маш их бодсон. УДЭТ-ын жүжигчин Б.Отгонбаг манай ангийн багш. Багш маань бидэнд кино болон тайзны урлагийн бүхий л ялгаа салгаж маш сайн зааж өгдөг. Багшийнхаа зааснаар л хичээгээд байлаа. Мөн найруулагчийн өгч байгаа үүрэг даалгавар маш чухал байдаг юм билээ. Мөн өөрийгөө маш сайн судалгаа хийсэн гэж бодож байгаа. Жүдочидтой чамгүй олон өдөр бэлтгэл хийж зүтгэсэн. Өөрт байгаа бүхнээ л гаргасан. Мэдээж алдаа оноо, чадахгүй зүйл байсан. Тэр бүхнийг чадварлаг хүмүүсийн ачаар даваад гарсан даа.

Спортсын сэдэвтэй кино жүжигчнээс маш өндөр ур чадвар шаардах нь мэдээж. Хувь хүний дотоод сэтгэл, зан чанарыг харуулахаас гадна спортын техникийг сайн сурах учиртай. Жүдо бөхийн мэхийг хийхэд техник талаасаа илгү худлаа харагдаж болохгүй шүү дээ?

“Киноны найруулагч шалгаруулалт хийж байхдаа л хэлж байсан. “Бидэнд биений тамирын уран чадвартайгаас гадна мэргэжлийн жүжигчний ур чадвартай хүн хэрэгтэй” гэж хэлж

бэ” гэж асуусан. Тэгэхэд Гавьяат тамирчин, дэлхийн аваргын хүрэл медальт Д.Сумъяагийн амьдралаас сэдэвлэж хийж байгаа кино шүү гэж хэлж байсан юм. Эмэгтэй тамирчныг сонгож авсан нь ч ийм учиртай юм билээ. Эрэгтэй хүн бол барилдахад асуудалгүй. Байгалиасаа л барилдах, тулалдахаар заяагдсан. Харин эмэгтэй хүн яаж тэр хэцүү бэрх бүхнийг давж, хүнд бэлтгэл хийж, амжилт гаргаж байгааг уран сайхны киногоор харуулах нь илүү сонирхолтой байсан. Яагаад ч юм

...Би энд нэг зүйлийг хэлэхийг хүсч байна. Д.Сумъяа эгчийн овог нэр нь Доржсүрэнгийн Сумъяа. Би энэ кинонд Доржсүрэнгийн Даваа гэдэг нэртэй тамирчны дүрд тоглосон. Сумъяа гэдэг чинь нэг дэх өдөр биз дээ. Даваа гэдэг чинь ч бас нэг дэх өдөр. Энэ бол эхнээсээ л бодож, төлөвлөж өгсөн нэр. Үүнийг ч хүмүүс анзаарах хэрэгтэй. Тэгэхгүй Д.Сумъяагаар менежмент хийлээ гээд яриад байгаа нь буруу. Би зориуд хэлмээр санагдаад байна...

эмэгтэй хүн барилдана гэхээр их хэцүү санагдаад байгаа юм даа. Би л гэхэд анх жүдогийн бэлтгэл дээр очиход эмэгтэй тамирчид татами дээр пад хийгээд унаад л. Тэр үед ямар хэцүү юм бэ гэж бодогдсон. Яг энэ бүхнийг, тэр дундаа эмэгтэй тамирчны амьдралыг харуулж байгаа нь маш сонирхолтой санагдсан.

Манай улсад олон шилдэг эмэгтэй тамирчин бий. Тэр дундаа жүдод. Гэтэл яагаад Д.Сумъяагийн амьдралаар кино хийхээр шийдсэн юм бол. Үүнийг зохиолч юм уу, найруулагчаас асуух нь илүү зохимжтой байх. Гэхдээ гол дүрийн жүжигчинтэй уулзсаных асуухгүй байж болохгүй байна л даа?

“Би бас энэ талаар зохиолч, продюссер Т.Номуунзул эгчээс энэ талаар асуусан. Зохиолч маань эхнээсээ л спортын сэдэвтэй кино хийхээр зорьж байсан юм билээ. Харин нэг удаа ажлаар жүдо бөхийн бэлтгэлийн зааланд очсон гэсэн. Гэтэл эмэгтэй бөхчүүд барилдаж байгаа нь өөрт нь их хэцүү санагдсан гэсэн. Пад хийгээд унаад л, яаж ингэдэг байна аа л гэж бодсон байгаа юм. Тэгээд жүдо бөхийн холбооныхонтой уулзаад, энэ санаагаа хэлээд, ярилцсан.

техникийг үзүүлэхэд хэцүү байсан болохоор тэгсэн юм уу?

“Риогийн олимп болоод Астанагийн дэлхийн аваргын тэмцээний зургийг цоолбороор авсан. Тийм том тэмцээний зургийг авахад би яг мэргэжлийн тамирчин шиг байж чадахгүй байгаа юм. Тийм болохоор тэр тамирчин охиноор нисэлттэй, техник шаарддаг мэхнүүдийг хийлгэж, зураг авахуулсан юм.

Кино зохиолд эхнээсээ л Риог тусгасан байсан уу. Эсвэл сүүлд нэмчихсэн юм уу?

“Би энэ кинонд тоглохдоо оруулсан юм. Энэ зургийг авахын тулд бид олон хүн цуглуулсан. Мөн шигшээ багийн тамирчид бидэнд маш их тусалсан. Тэдэндээ маш их баярлалаа гэж хэлмээр байна. Хэдийгээр кинонд тоглож байгаа ч гэсэн том тамирчидтай хамт, дэлхийн аваргын медалийг нь зүүгээд гараад ирэхэд хүмүүс хашгиралдахаар өөрийн эрхгүй уйлах гээд байгаа юм чинь. Яг л өөрөө дэлхийн аваргаас медаль хүртээд ирж байгаа юм шиг санагдсан. О.Балжинням аварга, Д.Төмөрхүлэг ах, М.Уранцэцэг эгч гээд олон том тамирчид манай киноны зурганд орж ирсэн. Энэ бол үнэхээр ховорхон тохиох үйл явдал байсан.

Уран бүтээл болгон ямар нэг санааг хэлдэг. Мэдээж тамирчин хүний жаргал, зовлонг харуулах л байх. Гэхдээ л түүнээс илүү гүн гүнзгий санаа байгаа болов уу?

“Энэ бол зөвхөн тамирчин хүний тухай өгүүлж байгаа юм биш. Одоогийн залууст маш том үлгэр дуурайлал болохоор уран бүтээл өөрөө л байдаг юм. Хүн өөрийгөө л ялж чадах юм бол юунд ч хүрч чадна гэсэн санааг өгөх юм. Манай киноны трейлер дээр гарч байгаа шүү дээ.

Өөрийгөө ялаагүй хүн өрөөлийг хэзээ ч ялахгүй” гэж. Энэ бол ерөнхийдөө хэлэх гэсэн санаа. Анх зохиолоо уншаад л би өөртөө өлгөж жишээ авсан шүү.

Залуу хүн хүсэл мөрөөдөлгүй байх шиг эмгэнэлтэй зүйл үгүй гэдэг. Нэгэнт уран бүтээлийн гараагаа үзэгчдийн таашаалд нийцэх өндөр магадлалтай кинонд тоглож эхлүүлээ. Цаашад ямар зорилго тавьж байна?

“Миний эхний тоглосон кино бүтээл болж байгаа гэж би бодож байна. Энэ том бүтээлд би багтаж чадсандаа баяртай байгаа. Манай киноны найруулагч Ж.Сэнгэдорж



©emmeric LE PERSON

бид кино группээрээ цуглаж үзсэн. Д.Сумъяагаа дэмжинэ, дээлийнх нь захыг мушгина гээд л үзсэн дээ. Японы бөхийг цэвэр ялахад нь бүгдээрээ уйлаад, маш их баярласан. Эх орондоо ирэхэд нь бид бүгдээрээ хамт тоссон. Д.Сумъяа эгч Астанагийн дэлхийн аваргаас хүрэл медаль хүртсэн шүү дээ. Тэр үйл явдлыг бид кинодоо оруулсан юм. Энэ зургийг авахын тулд бид олон хүн цуглуулсан. Мөн шигшээ багийн тамирчид бидэнд маш их тусалсан. Тэдэндээ маш их баярлалаа гэж хэлмээр байна. Хэдийгээр кинонд тоглож байгаа ч гэсэн том тамирчидтай хамт, дэлхийн аваргын медалийг нь зүүгээд гараад ирэхэд хүмүүс хашгиралдахаар өөрийн эрхгүй уйлах гээд байгаа юм чинь. Яг л өөрөө дэлхийн аваргаас медаль хүртээд ирж байгаа юм шиг санагдсан. О.Балжинням аварга, Д.Төмөрхүлэг ах, М.Уранцэцэг эгч гээд олон том тамирчид манай киноны зурганд орж ирсэн. Энэ бол үнэхээр ховорхон тохиох үйл явдал байсан.

Уран бүтээл болгон ямар нэг санааг хэлдэг. Мэдээж тамирчин хүний жаргал, зовлонг харуулах л байх. Гэхдээ л түүнээс илүү гүн гүнзгий санаа байгаа болов уу?

“Энэ бол зөвхөн тамирчин хүний тухай өгүүлж байгаа юм биш. Одоогийн залууст маш том үлгэр дуурайлал болохоор уран бүтээл өөрөө л байдаг юм. Хүн өөрийгөө л ялж чадах юм бол юунд ч хүрч чадна гэсэн санааг өгөх юм. Манай киноны трейлер дээр гарч байгаа шүү дээ.

Өөрийгөө ялаагүй хүн өрөөлийг хэзээ ч ялахгүй” гэж. Энэ бол ерөнхийдөө хэлэх гэсэн санаа. Анх зохиолоо уншаад л би өөртөө өлгөж жишээ авсан шүү.

Залуу хүн хүсэл мөрөөдөлгүй байх шиг эмгэнэлтэй зүйл үгүй гэдэг. Нэгэнт уран бүтээлийн гараагаа үзэгчдийн таашаалд нийцэх өндөр магадлалтай кинонд тоглож эхлүүлээ. Цаашад ямар зорилго тавьж байна?

“Миний эхний тоглосон кино бүтээл болж байгаа гэж би бодож байна. Энэ том бүтээлд би багтаж чадсандаа баяртай байгаа. Манай киноны найруулагч Ж.Сэнгэдорж

“За Жинжиймаа, кино гэдэг бол ийм, ийм учиртай шүү дээ. Цаашдаа уран бүтээлд тоглож байгаарай. Зүгээр л нэг халтуурны гэж болохоор кино Монголд зөндөө л гарч байна. Тийм кинонд биш, жинхэнэ уран бүтээлд тоглож байвал түүн шиг жаргал гэж байдаггүй юм” гэж захисан. Би нэг хэсэг их гоё мэдрэмжийг авч явлаа. Ж.Сэнгэдорж найруулагчийн хийж байгаа киноны гол дүр гэхээр л хүмүүс бахдаад л. Түүнээс би уран бүтээлийн амт, сайхан мэдрэмжийн заримыг нь амталж байгаа юм чинь. Найруулагч гэдэг үнэхээр агуу хүмүүс. Зохиол уншихад нэг өөр. Харин найруулагчийн харах өнцөг огт өөр. Бид болохоор “Энэ зургийг ингээд л авна даа” гэж бодож байтал бодоогүйг бодож, сэтгээгүйг сэтгэж, зүүдлээгүйг зүүдэлчихээд л босоод ирдэг юм билээ шүү дээ, найруулагч хүмүүс чинь. Түүнийг нь бахдаад л, суралцаад, зөвлөгөөг нь дагаад, хэрэгжүүлэхийг хичээнэ. Цаашид уран бүтээлд л оролцож байа гэж бодож байгаа.

Чиний энэ киноноос авч үлдсэн хамгийн том олз чинь юу вэ?

“Мэргэжлийн уран бүтээлч гэж юу байдаг юм бэ гэдгийг ойлгосон. Мэргэжлийн кино баг уран бүтээлээ үзэгчдэд хүргэхийн тулд яаж ажилладаг. Яаж мэргэжлийн дагуу бүтээлээ туурвидаг вэ гэдгийг ойлгож авлаа. Би СУИС-ийг төгсөхөөсөө өмнө энэ кинонд тоглож чадсандаа, тийм завшаан надад олдсонд баяртай байгаа. Юугаа ч мэдэхгүй нэг нөхөр л явж байлаа шүү дээ. Гэтэл энэ кино багтай хамтарч ажилласнаар нэг шат ахиж чадсан. Миний цаашдын амт амьдралд маш том түлхэц боллоо. Дээрээс нь маш том төлөвшлийг олж авсан. Манай сургуулийн оюутнууд кинонд тоглохын тулд зөвшөөрөл авдаг. Ж.Сэнгэдорж найруулагч маань багш руу утасдаад “Танай Жинжиймааг киноныхоо гол дүрд тоглуулахаар авлаа” гэж хэлсэн. Гэтэл багш “Наадахаа жүжигчин болгоод явуулаарай” гэхгүй юу. Тэгэхэд зургийн дарга Тогоосоо эгч маань “Жүжигчин байтугай хүн болгоод явуулна” гэж хэлж байсан юм. Тэр ч ёсоор би яаж хүн шиг байх ёстойг ч сайн мэдэрсэн. Энэ бүхэн миний киноноос авч үлдсэн хамгийн том олз юм даа.

# ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Тиймээс жилийн дөрвөн улиралд гадаа гандаж, хөдөө хөхөрч мал сүргийнхээ ашиг шимээр л амьдрах малчдын хөдөлмөр үнэгүйдэх, нөгөө талаар, хэд хэдэн ченжийн гар дамжиж үнэ нь хэд нугарсан, хаанахын, хэний, эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх нь ч тодорхойгүй малын махыг нийслэлчүүд бид худалдан авч хэрэглэдэг бичигдээгүй хууль үйлчилсээр удлаа. Тэгвэл мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбартаа анхдагч 70 жилийн түүхт “Мах Импэкс” ХК-ийнхан малчиддаа ч, иргэддээ ч хэрэгтэй нэгэн хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн таатай мэдээг уншигч танд дуулгая. Нийслэлчүүдээ эрүүл аюулгүй мах махан бүтээгдэхүүнээр хангаж ирсэн эдний хамт олон “Малчдыг дэмжих хөтөлбөр”-ийг санаачлан боловсруулж, энэ сарын 1-нээс эхлэн туршилтын шугамаар хэрэгжүүлж эхэлжээ. Улмаар туршилтын хугацаанд уг хөтөлбөр “Онц” дүн авсан учир орон даяар хэрэгжүүлэхэд бэлэн болжээ. Хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа өчигдөр тус компанийн төв байранд зохион байгуулагдсан юм. Энэхүү үйл ажиллагаанд Мах Импэкс ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Будрагчаа, тус компанийн Хиам консервийн үйлдвэрийн Гүйцэтгэх захирал Б.Бадмаа, УИХ-ын гишүүн О.Баасанхүү, Монголын махны холбооны гүйцэтгэх захирал Б.Очирбат нарын хүндтэй хүмүүсээс гадна малчид, зочид төлөөлөгчид оролцлоо. Үйл ажиллагааг нээж Г.Будрагчаа захирал уг хэлсэн бөгөөд тэрбээр “Малчдыг дэмжих хөтөлбөрийг энэ сарын 1-нээс эхлэн туршилтын маягаар хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд боломжтой гэдэг нь батлагдсан. Сүүлийн жилүүдэд манай улсын малын тоо толгой тасралтгүй өссөн үзүүлэлттэй байгаа. Гэвч махны экспорт байхгүй, махны түүхий эдийн үнэ унасан, арьс шир, дайвар бүтээгдэхүүн гэх мэт алтаар үнэлэгдэх түүхий эд өнөөдөр гудамжинд хаягдаж байна шүү дээ. Тиймээс малчдад тулгарч буй бэрхшээлийг даван туулахад нь туслах, дэмжих зорилгоор энэ хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байгаа юм” гэлээ.

## Малчдад зургаан боломжийг санал болгоно

Монгол Улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан санаачлан хэрэгжүүлж буй “Малчдыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Мах Импэкс ХК малчиддаа зургаан боломжийг санал болгож байгаа юм билээ. Тодруулбал, малын махыг үйлдвэрийн аргаар төхөөрөх, малын махыг нь хадгалах, үйлдвэрийн хэрэгцээндээ худалдан авах, сүлжээ дэлгүүрүүдэд зуучлан борлуулах, арьс шир, дайвар бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулж эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээс хямдаар нийлүүлэх зэрэг үйлчилгээг санал болгож буй аж. Шат дамжлагын тухайд малчид малаа гарал үүслийн бичигтэйгээр Мах Импэкс ХК-д нийлүүлэх бөгөөд тус компанийн мэргэжлийн малын эмч тусгайлсан үзлэг хийсний дараа малыг үйлдвэрийн аргаар төхөөрнө. Улмаар малчин үнийн хувьд

# “МАХ ИМПЭКС” МАЛЧДАА ДЭМЖИНЭ

–Тэд малчдад хэд хэдэн боломжийг санал болгож байна–



...Хөтөлбөр маань нэг талаар малчдаа дэмжинэ, нөгөө талаар нийслэлийн иргэдээ эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан мах махан бүтээгдэхүүнээр хангахад чиглэгдэж байгааг онцолмоор байна. Хөтөлбөрийн хүрээнд эхлээд бид малыг нь үйлдвэрийн аргаар төхөөрнө. Дараа нь малчдад хоёр боломжийг санал болгож байгаа. Тэд бидэнд махаа худалдаж болно. Эсвэл Хүчит шонхор зах дээр зарж болно. Зарахад нь бид тусгай зориулалтын хөргүүртэй машинаар үйлчилнэ...

Цаашдаа махны үнэ өссөн тохиолдолд үнээ өсгөнө, огцом буурвал бага хэмжээнд бууруулахаар мөн тооцжээ. Харин Мах импэкс компанийн санал болгож буй үнийн хувьд талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд тодорхой гэрээ байгуулсны үндсэн дээр тухайн малчны махыг сүлжээ дэлгүүрүүдэд худалдах, зуучлан борлуулах үйлчилгээг санал болгоно. Хэрэв малчин худалдах сонирхолгүй зөвхөн үйлдвэрийн аргаар төхөөрүүлэх үйлчилгээ авч, хавар мах үнэд орсон үед худалдах сонирхолтой байвал хамгийн бага нөхцөлтэйгөөр 16000 тоннын багтаамжтай зориулалтын хөргөлтийн агуулахад махыг нь хадгалах үйлчилгээг санал болгох юм байна. Эцэст нь тухайн малчин Мах Импэксийн санал болгосон үнээр худалдах хүсэлтэй тохиолдолд малаа тууж ирсэн өдөр нь үнийн дүнгийн нь 70 хувийг бэлэн өгнө. Улмаар 30 хувьд нь зээлийн гэрээ байгуулан тодорхой хугацааны дараа олгох, түүнчлэн 10 хувьд нь

нийслэлчүүд бидний мах, махан бүтээгдэхүүний чанар баталгаажих аж. Хөтөлбөр арваннэгдүгээр сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжлэх бөгөөд энэ жилийн хувьд тус компани нийтдээ 2000 тонн махыг өөрийн хэрэгцээндээ зориулан нөөцлөхөөр төлөвлөжээ. Харин дараа жил хэмжээгээ нэмэгдүүлж 5000 тонн болгох зорилт тавьсан байна. “Малчдыг дэмжих хөтөлбөр”-ийн ачаар малчид гар дээрээ бэлэн мөнгөтэй болж, нийслэлчүүд ч чанартай махаар хангагдан, махны үнэ хавар намартаа тогтворжих давуу талтай гэдгийг холбогдох хүмүүс онцолж байлаа. Малчид ч хөтөлбөрийн үр дүнг сайшааж байв.

## Малчид хөтөлбөрийг сайшааж байна

Нээлтийн үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн хүндтэй зочдын нэг бол малын махаа боломжийн үнээр тус компанид худалдаж, үр

малчин Д.Батгэрэлтэй бид уулзлаа. Тэрбээр “Үндэсний ууган үйлдвэр Мах Импэкс ХК малчдаа дэмжих хөтөлбөр боловсруулсанд юун түрүүн талархаж буйгаа илэрхийлэе. Малчдын амьдралд тус дэм болохуйц нүдээ олсон хөтөлбөр болсон гэж үзэж байгаа. Сая гэхэд Булган аймгийн таван сумаас 2000 орчим хонь, 300 гаруй үхэр авчирч тушаалаа. Зам сайхан болохоор тууж ирээд л тушаачихаж байна. Үнэ ханш нь ч боломжийн. Ченжийн гар дамжихгүй олон ажиллагаагүй болохоор амар юм. Малд тавигдах дундаж жин гэж бий. Жиндээ хүрч байвал асуудалгүй. Тарга тэвээрэг сайтай, сайн малууд туснаагдаж байна. Өмнө нь Налайх эсвэл Эмээлт дээр аваачиж нядлуулаад, дараа нь Хүчит шонхор зах дээр аваачиж зардаг байсан. Цаг хугацааг хэмнэсэн. Үнэ нь ч бодитой юм” гэж ярилаа. Харин түүний хажууд суух цайвар өнгийн торгон дээл, бүрх малгайгаар гоёсон Завхан аймгийн Илэцэн-Уулсумын сайн малчин Г.Дашдорж “Малчдад



тохиролцсон тохиолдолд тус үйлдвэрт худалдах боломжтой гэнэ. Одоогийн байдлаар хонины махыг 4000, ямааны махыг 3100, үхрийн махыг 4500 төгрөгийн ханшаар худалдан авч байгаа юм байна. Энэ ханш өнөөдөртөө зах зээлд хамгийн өндөр үнэ аж.

үндэсний үйлдвэрлэлийн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээс хямдаар нийлүүлэхийг малчдад санал болгох юм. Ийм хэд хэдэн дамжлагаар малчид, Мах Импэкс ХК-тай хамтран ажиллаж, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эцсийн дүндээ

хүүхдийнхээ сургуулийн бэлтгэлийг базаасан хэмээн ярих малчид байлаа. Улбар шар өнгийн давуун дээл өмсч, орос хромон гутал жийсэн, магнайд нь бурзайх хөлсөө үе үеэ арчин зочдын суудалд тухлах Булган аймгийн Дашинчилэн сумын

ойрын үед үнэхээр хэрэгтэй хөтөлбөр. Ченжийн гар дамжуулахгүй, чирэгдэлгүй. Дайвар бүтээгдэхүүнийг нь ч борлуулах шаардлага алга. Махны үнэ өртөгт санаа зовох ч шаардлага байхгүй. Энэ хөтөлбөрийг малчдад сайн сурталчлах шаардлагатай

байна. Зах зээлийн үнэ ханш нь ч сайн. Мах Импэкс өмнө нь удаа дараа мах нийлүүлж байсан. Миний хувьд барагцаагаар гурав, дөрвөн тонн мах тушаасан болов уу. Тооцож үзээгүй юм байна” хэмээн бидэнд хуучилсан юм. “Мах импэкс”-ийнхний малчдаа дэмжих хөтөлбөрийг тэд ингэж дүгнэлээ. Хөтөлбөрийн нээлтийн үеэр бид Г.Будрагчаа захиралтай уулзаж, санал бодлыг нь сонирхлоо.

## Г.Будрагчаа: Алтаар үнэлэгдэх түүхий эдийг гудамжинд хаяж байна

*/Мах импэкс ХК-ийн гүйцэтгэх захирал/*

Малчдыг дэмжих хөтөлбөрийг энэ сарын 1-нээс туршилтаар хэрэгжүүлж эхэлсэн. Туршилтын хугацаанд боломжтой гэдэг нь батлагдсан. Хөтөлбөр наймдугаар сарын 1-нээс ирэх арваннэгдүгээр сарын 15 хүртэл үргэлжилнэ. Энэ хугацаанд малчдын малын мах, түүхий эдийн үнэ хамгийн их уналттай байдаг үе. Мах нь ч амархан муудах гээд байдаг талтай. Харин ченжүүд малыг нь хямд үнээр худалдан авч хадгалж байгаад хавар мах үнэд орох цагаар гаргаж, нийслэлчүүдэд үнэтэй зардаг жишиг тогтсон гэхэд хэнийдхэйгүй. Энэ мэт бэрхшээлийг даван туулах, малчдаа дэмжих үүднээс хөтөлбөрөө хэрэгжүүлж байна. Бидний ажлыг хотын захиргаа, Хүнс, хөдөө аж ахуйн яам, төр засаг тодорхой хэмжээгээр дэмжиж ажиллаж байгаа. Хөтөлбөр маань нэг талаар малчдаа дэмжинэ, нөгөө талаар нийслэлийн иргэдээ эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан мах махан бүтээгдэхүүнээр хангахад чиглэгдэж байгааг онцолмоор байна. Хөтөлбөрийн хүрээнд эхлээд бид малыг нь үйлдвэрийн аргаар төхөөрнө. Дараа нь малчдад хоёр боломжийг санал болгож байгаа. Тэд бидэнд махаа худалдаж болно. Эсвэл Хүчит шонхор зах дээр зарж болно. Зарахад нь бид тусгай зориулалтын хөргүүртэй машинаар үйлчилнэ.

Манай сүлжээ дэлгүүрээр зарж өгч ч болно. Мөн малчин өөрөө хүсвэл маш хямд нөхцөөр хөргүүртэй зооринд хадгалж өгөх боломжтой. Экспортлох боломж гарвал экспортлоно. Нөгөө талаар арьс шир, дайвар бүтээгдэхүүний асуудал бий. Өнөөдөр хотын зүүн болон баруун хэсгийн жалга бүрт алтаар үнэлэгдэх түүхий эд хаягдсан байна. Нэхий, өлөнг хог шиг л хаягдсан байх жишээтэй. Үүнийг үнэтэй болгоход малчидтайгаа хамтарч ажиллана. Малчдыг дэмжихийн зэрэгцээ үндэсний үйлдвэрлэлээ мөн дэмжих хэрэгтэй. Тиймээс малчдын махны төлбөрийн 70 хувийг бид эхлээд өгнө. Үүнээс 45 хоногийн дараа 20 хувийг нь гэрээ хийгээд өгнө. Үлдсэн 10 хувьд нь Монголд үйлдвэрлэгдсэн хивэг, гурил, гоймон гэх мэт малчдад нэн хэрэгцээт бүтээгдэхүүнийг хамгийн хямд үнээр дүйцүүлэн малчдад хүргэх ажлыг зохион байгуулна. Ийм ажил туршигдсан. Амжилттай болсон. Тиймээс бусад махны үйлдвэрүүддээ ч уриалмаар байна. Бид стандартын шаардлага хангасан мах идэх ёстой. Энэ утгаараа хөтөлбөр маань цаашид илүү өргөн хүрээг хамрах байх гэж найдаж байна.




Тал нутгийн цахим мэдээлэл

# ДЭЛХИЙ

## БУДДЫН ШАШНЫ СОЁЛЫН ӨВ СҮЙРЭВ



### Б.ДАВААХҮҮ

Италийн төв хэсэгт өнгөрөгч лхагва гарагийн үүрээр 6.2 магнитудын хүчтэй газар хөдлөлт болсны улмаас уулсын жижиг хотын тэн хагас нь сүйрсэн тухай мэдээллийг бид өмнөх дугаартаа хүргэсэн. Тэгвэл үүнээс ч илүү хүчтэй газар хөдлөлт Мьянмарт болжээ. Италид болсон газар хөдлөлт орон нутгийн цагаар шөнө дунд буюу 03:30 цагийн үед болсон бол Мьянмарт эд өдрийн үдэш 6.8 магнитудын хүчтэй газар хөдөлжээ. Тус улсын хамгийн том хот Янгоноос 500 орчим

км зайтай газарт газар хөдлөлт болсон бөгөөд газар хөдлөлтийн гүн нь 84 км байжээ. Байгалийн энэхүү гамшигт үзэгдлийн улмаас дэлхий дахинаа алдартай Буддын шашны соёлын өв байрлах Паган хот ихээхэн хохирол амссан байна. Жуулчид олноороо очдог Паган хотын хэдэн зууны түүхтэй Буддын сүмүүд газар хөдлөлтийн улмаас эвдэрч гэмтсэн байна. Тус хотод нүүлсэн хохирол аялал жуулчлалын салбарт нөлөөлөх байгууллагаас мэдээлжээ. Газар хөдлөлтийн голомт Мьянмарын төв хэсэгт

байжээ. Энэ үеэр гурван хүн амиа алдаж, байшин барилга нурж сүйдсэн байна. Газар хөдлөлтийн голомтоос 30 км зайд орших Паган хотод 3000 орчим буддын сүм, хөшөө дурсгалууд байдаг бөгөөд дэлхий дахинаа Буддын шашны өв соёлоороо алдаршжээ. Тэгвэл энэ удаагийн газар хөдлөлтөөр 185 Буддын сүм нурж, эвдэрсэн байна. Тэдний дунд 12 дугаар зууны үед баригдсан, уран зургаараа алдартай Суламани сүм байсан бөгөөд сүмийн барилгын орой нурж, нуралт үүсч, дахин жуулчид хүлээн авахааргүй болж хаалгаа барихад хүрчээ. Сүм Паган хотын баруун өмнөд хэсэгт байрладаг, жуулчдын хамгийн их зорин очдог газрын нэг аж. Сүмийн барилга 12 дугаар зууны үе буюу 1183 онд Нарашатиситу хааны зарлигаар сүндэрлэж байжээ. Гэвч 1975 онд болсон газар хөдлөлтийн дараа дахин сэргээн босгосон байдаг. Сүмийн дотор талын тоосго,

чулуу дээр гайхалтай уран зургууд дүрслэгдсэн байдаг ажээ. Суламани сүмийг 1994 онд дахин барьж байжээ. Газар хөдлөлтийн дараах сүмийн нөхцөл байдлыг орон нутгийн нэгэн дэлгүүрийн худалдагч залуу “Сүм тэр чигтэй чирэн хөдөлж, тоос агаарт босч байсан. Газар хөдлөлт болох үед сүмийн дотор талд жуулчид байсан. Тэд тусламж гуйн орилж, сүмийг орхин зугтааж байлаа. Бидний итгэж суслэн биширдэг буддын шашны сүм нурчихлаа. Харамсандаа хэлэх үг ч олдохгүй байна” гэж ярьжээ. Мьянмарын Засгийн газар Паганы өвийг Дэлхийн соёлын өвд бүртгүүлэхээр сүүлийн жилүүдэд эрчимтэй ажиллаж байсан билээ. Харин байгалийн гамшигт үзэгдлийн дараа сүмийг сэргээн засварлах шаардлага тулгарсны зэрэгцээ, аялал жуулчлалын салбарт нөлөөлж болзошгүй байна.

### Италид нас барагсдын тоо 247-г давлаа

Газар хөдлөлтийн улмаас амь эрсэдсэн хүмүүсийн тоо 247 болж нэмэгдлээ гэж Италийн Засгийн газрын албаны хүмүүс мэдэгдлээ. Италийн төвийн нутгийн Лацио мужид 6.2 баллын хүчтэй газар хөдлөлт болсон юм. Тус мужийн 2600 орчим хүн амтай, уулархаг газарт оршдог Амастриче хот газар хөдлөлтөд хамгийн их эргэжээ. Хотын бараг бүх байшин барилга эвдэрч нуржээ. Энэ хотод алдартай амрагт зугаалгын газрууд олон байдаг бөгөөд Ром болон Италийн бусад хэсгээс

зундаа жуулчид олноороо очдог аж. Газар хөдлөлтөд нэрвэгдсэн хохирогчдын олонхи нь жуулчид бололтой. Орон гэргүй болсон хүмүүс аврах багийнхны босгосон майханд урд шөннийг өнгөрүүлжээ. Нурангид дарагдсан хүмүүсийг эрэх болон аврах ажиллагаа ид өрнөж байна. Гамшигт өртсөн бүсэд Италийн Ерөнхий сайд Маттео Ренци лхагва гарагт очиж, нөхцөл байдалтай танилцаад “Хүмүүсийг аврахын төлөө Засгийн газар чадах бүхнээ хийх болно” гэжээ.

### Жолоочгүй таксиг түршиж эхэлжээ

Сингапурт жолоочгүй такси үйлчилгээг түршиж эхэлжээ. Тодруулбал, “uTaxi” такси компанийн компьютерийн программд суурилсан автомат жолоодлоготой машинаар энэ үйлчилгээг үнэ төлбөргүй түршиж байгаа аж. Үйлчлүүлэгчдийн хувьд автомашины компьютертэй гар утсаараа холбогдсоноор явах чиглэлээ оруулан үйлчлүүлэх юм байна. Одоогоор зургаан ширхэг автомашиныг туршилтаар үйлчилгээнд явуулж байгаа ч энэ оны сүүлч гэхэд 20 болгохоор төлөвлөжээ. Улмаар 2018 он гэхэд Сингапурын нийтийн тээврийн үйлчилгээнд 900 мянга орчим такси үйлчилж байгаа гурав дахин багасгах зорилго тавьсан байна. “Renault Zoe” болон “Mitsubishi” компанийн хамтран зохион бүтээсэн жолоочгүй автомашин нь жолоочийн суудлын оронд компьютерийн хянах самбарыг байрлуулснаар үйлчлүүлэгч явах чиглэл, болон км, үнэ зэргийг хянах боломжтой. Түүнчлэн радартай ижил ажиллагаатай лазер системийн тусламжтайгаар автомашин эргэн тойрны эд зүйлс болон замын гэрлэн дохио өөрчлөлтөд зохион ажиллах аж. Жолоочгүй таксиг түршсэн зарим иргэд “Сүнстэй автомашинд суусан юм шиг санагдсан” хэмээн итгэж ядан ярсан байна. Түүнчлэн хэдэн жилийн өмнөөс “Google”, “Volvo” компаниуд жолоочгүй автомашин түрших үйлчилгээг түршиж байгаа юм.



## ДАРААХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

username	plateno	owner_name	mark_model	certificate_number	actiondate
И.Ловонгончиг	8049ора	Э.Наянгай	Volkeswagan	ая0018726 06,31	2016-04-01
И.Ловонгончиг	8704унз	Д.Сандуйрагчаа	Ford Everest	ая0165706 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	8858 орх	Неткапитал ббсб	Nissan Skyline	ая1093700	2016-04-01
И.Ловонгончиг	7242орх	Б.Цэрмаа	MMC pajero	ая0898015 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	7863оро	Неткапитал ббсб	Toyota Cresta	ая0739539	2016-04-01
И.Ловонгончиг	5774орх	Г.Түвшинбаяр	Toyota Sprinter	ая0780701 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	9224орх	Н.Батгэрэл	Toyota Prius	ая0762753	2016-04-01
И.Ловонгончиг	7690оро	Б.Батбаатар	Honda Fit	ая1063215 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	7690оро	Б.Батбаатар	Honda Fit	ая1063215	2016-04-01
И.Ловонгончиг	9224орх	Н.Батгэрэл	Hyundai mihtgy	ая1158917 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	5066орх	Ц.ЦУС ТӨХК	УАЗ 2206	ая0005906 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	2123орх	Б.Нансалмаа	Toyota Prius	ая1044124 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	6087орх	Д.Хишгэ	Hyundai Grace	ая0267676 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	3945хоу	П.Анхмандах	Nissan Mistral	ая0522720	2016-04-01
И.Ловонгончиг	6159оро	Я.Батзориг	Daihatsu Hijet	ая0934310 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	9793оро	Ц.Ганболд	Hyundai Porter	ая0700166 03,31	2016-04-01
И.Ловонгончиг	6155оро	С.Цэрэмжаргал	Toyota Chaser	ая0700104 03,31	2016-04-01
Б.Цогтгэрэл	6205арх	оюунцэцэг	toyota raum	0986486	2016-04-01
Н.Гэрэлмаа	32-80 унз	Н.Оюунчимэг	T.Porter	0048360	2016-04-01
Б.Цэгэмгаа	8541уб	тайга инвест ххк	бульдозр	932369	2016-04-01
А.Сарантуяа	6190уц	гуртын тавилан ббсб	kia retonina	084140	2016-04-01
Б.Цэгэмгаа	3617унх	эрдэмбилэг	навара	294485	2016-04-01
Б.Цэгэмгаа	3617унх	эрдэмбилэг	навара	294485	2016-04-01
Н.Гэрэлмаа	85-67 уби	Б.Батбаяр	Sinotruk	0285097	2016-04-01
Т.Мөнх-Оргил	5195уб	гайбаатар	nissan joy	0172145	2016-04-01
А.Сарантуяа	3621уна	ганзориг	golamer	430512	2016-04-01
И.Ловонгончиг	4515гч	Өлзийорших	Toyota mark 2	ая075372	2016-04-01
Н.Шүрэнтогтоо	3957уб	иданболд	l.chaser	768956	2016-04-01
Б.Цэгэмгаа	7584УНЧ	ЖАМЬЯННАГВА	ПРОГРЕСС	966626	2016-04-01
Н.Гэрэлмаа	71-18 унз	Мөнхбаяр	T.Estima	0742257	2016-04-01
Т.Очирдарь	7875УНМ	Төрийн банк	Hyundai verna	0803355	2016-04-04
Н.Гэрэлмаа	21-88 уб	линксповер копе ххк	трактор	0251893	2016-04-04
Н.Гэрэлмаа	42-74 унк	Ц.Өлзийжаргал	K.bongofrontier	0580642	2016-04-04
Т.Уртнасан	0743убч	ориглболд	kia pronter	445484	2016-04-04
Д.Энхдэлгэр	2096унс	гуртын тавилан ббсб	T.PROBOX	0849160	2016-04-04
Д.Энхдэлгэр	0088УНЛ	ННО-ЭТАЛОН ХХК	ЛАНЦ 100	АЖ0195152	2016-04-04
А.Сарантуяа	2747унл	батболд	орж3321	093321	2016-04-04
А.Сарантуяа	8472унк	доржсүрэн	приус	692103	2016-04-04
Ч.Оюунтуяа	1832са	Цэнджав	KIA FRONTIER	тя0935871	2016-04-04
Т.Очирдарь	2143УНП	Залуу монгол оч ххк	Hyundai verna	0863585	2016-04-04
А.Гарьдмагнай	9698ДАР	Гэрэлтуяа	S.Rexton	0848275	2016-04-04
Б.Мөнхгэрэл	1250СЭУ	Х.Үүрийнтуяа	Northbenz	0496527	2016-04-04
Б.Мөнхгэрэл	4515гч	Х.Үүрийнтуяа	ZTC	0496526	2016-04-04
Б.Мөнхгэрэл	6678АЧ	П.Бат-Эрдэнэ	Чиргүүл	0154270	2016-04-04
Ч.Оюунтуяа	7682уб	ти би эс эс ххк	ZIL MM-555	тя0489828	2016-04-05
Т.Очирдарь	4251УНЯ	ЖЭЙ ПИ ЭМ БИ ТН ХХК	Toyota mark-2	0846498	2016-04-05
А.Сарантуяа	2178уб	зууны чавдас ххк	ланд-80	913428	2016-04-05
Б.Цэгэмгаа	5564учо	тэрбиш	бенз	866829	2016-04-05
Н.Гэрэлмаа	00-28 унз	С.Батболд	ford	0281802	2016-04-05
Н.Шүрэнтогтоо	7162уб	лауэрложистикс ххк	liugong	3333125	2016-04-05
Д.Энхдэлгэр	1837уб	и.аззаяа	hyundai grace	1135657	2016-04-05
Б.Уянга	1497 ТӨА	Төрийн банк	Ssang Yong Istana	0812653	2016-04-05
Б.Уянга	1389 ТӨВ	Шүрвэ Батхүү	Kia Bongo	0166078	2016-04-05
Б.Уянга	1471 ТӨВ	Лхагва Батбаяр	ZIL 130	9621640	2016-04-05
А.Сарантуяа	5996убн	болор-эрдэнэ	истана	1007594	2016-04-05
Ч.Оюунтуяа	6559учо	Амаржанд	toyota corolla	тя0729149	2016-04-05
Б.Мөнхгэрэл	4139ГЧ	БААТАР ЭНХБАЯР	QDJ	00610795	2016-04-05
Т.Очирдарь	5327УБО	Баасанбат	Toyota land-cruiser 80	0960686	2016-04-05
Ч.Оюунтуяа	2413унд	Амартүвшин	Kia Lotze	тя0681279	2016-04-05

Т.Очирдарь	2277УНЧ	Бат-эрдэнэ	Subaru impreza	0994114	2016-04-06
Б.Цэгэмгаа	5397унг	баярсайхан	аксент	509523	2016-04-06
Б.Цэгэмгаа	5397унг	баярсайхан	аксент	509523	2016-04-06
Н.Шүрэнтогтоо	4672унз	ц.нэмсүрэн	t.susceed	190512	2016-04-06
А.Сарантуяа	5266унг	гуртын тавилан ббсб	приус	912261	2016-04-06
Т.Очирдарь	3989УНХ	Бичил глобус ххк	Hyundai grace	0897380	2016-04-06
Т.Очирдарь	1895УНА	Хан агь ххк	Hyundai accent	0866379	2016-04-06
Т.Уртнасан	7791унз	болорчдун	prius	883329	2016-04-06
Т.Уртнасан	8772унз	мэргэншагай	bmw-318	789106	2016-04-06
Б.Уянга	1298 ОЧ	Лхагва Баярмагнай	ГКБ 817	1840414	2016-04-06
Т.Очирдарь	6930УБУ	Мөнхжаргал	Kia bongo	1073195	2016-04-06
Д.Цэгээ	3563бул	Энхбаатар	KIA BONGOF-RONTPIER	0780911	2016-04-06
Т.Очирдарь	4670УБЭ	Очирбат	Toyota corolla	1149332	2016-04-07
Ч.Оюунтуяа	5829унз	Хас банк	Kia Bongo	ая0035969	2016-04-07
Б.Уянга	5071 ТӨВ	Сосор Баярсайхан	Hyundai Sonata II	0377726	2016-04-07
Б.Уянга	2520 ТӨВ	Борнуур сумын ЗДП	KAMA KMC 3040	0238753	2016-04-07
Т.Очирдарь	7441УБВ	Төгс зам ххк	Ford ranger	0303107	2016-04-07
Н.Гэрэлмаа	68-27 унз	Д.Баатарчулуун	T.Lexus470	0106126	2016-04-07
Б.Ганболд	7493убн	Мөнхбат	sonata 2	ая0865512	2016-04-07
Т.Очирдарь	0004УБК	Золзаяа	Toyota prado	01178915	2016-04-07
Н.Гэрэлмаа	32-83 унс	М.Баасансүрэн	H.Accent	0664195	2016-04-07
Б.Уянга	2011 ТӨЗ	Ойдов Отгондорж	Shineray XY150	1801998	2016-04-08
А.Гарьдмагнай	2399ард	Батболд	ISTANA	0327611	2016-04-08
Т.Уртнасан	0493унз	ариунболд	corolla	961033	2016-04-08
Н.Гэрэлмаа	80-46 уну	альфамарал ббсб	T.Prius	1134051	2016-04-08
Б.Цэгэмгаа	0254унн	батзориг	приус	1150865	2016-04-08
Б.Цэгэмгаа	0254унн	батзориг	приус	1150865	2016-04-08
Д.Энхдэлгэр	6384унг	б.манлайбат	Toyota prius	0818358	2016-04-08
Б.Цэгэмгаа	4354унг	одгэрэл	mnc lancer	0010436	2016-04-08
Д.Энхдэлгэр	3159унц	энх цэцүүн ххк	hyundai porter	0728529	2016-04-08
Т.Очирдарь	1717УБР	Баяраа	Landrover	1124421	2016-04-08
Б.Мөнхгэрэл	0113дга	Ж.ЦЭВЭЭНЦОРЖ	UAZ31512	0654496	2016-04-08
Б.Цогтгэрэл	8462унэ	ачигмаа	prius	0257212	2016-04-09
А.Сарантуяа	1656убн	эрдэмбилэг	бонго	296656	2016-04-11
Д.Цэгээ	1625бул	мядагжаргал	h.porter	0345851	2016-04-11
Д.Энхдэлгэр	7599унл	д.энжаргал	l.tallex	360778	2016-04-11
А.Гарьдмагнай	651ЦДАР	ОТОНБАЯР	T.Landcruiser	0839640	2016-04-11
Т.Уртнасан	1341уб	отгонжаргал	mazda demo	0561655	2016-04-11
Б.Цогтгэрэл	5165унн	компорт импекс	hino ranger	0051835	2016-04-11
Н.Гэрэлмаа	49-07 уне	пүрэвдэмбэрэл	Paz-3205	0622102	2016-04-11
Б.Цэгэмгаа	8636убно	ганхуяг	familia	120586	2016-04-12
Б.Цэгэмгаа	8951убн	золбоо	chaser	1027220	2016-04-12
Г.Одонгарав	5161ува	О.Гансүх	HYUNDAI Accent Verna	0163476	2016-04-12
Г.Одонгарав	1662ува	Ц.Лхагвасүрэн	NISSAN VAN-NETE	0347272	2016-04-12
Ч.Оюунтуяа	4546убн	Болдбаатар	hyundai grace	ая0036392	2016-04-12
Г.Одонгарав	7351ува	О.Гансүх	ZIL MMZ 4505	0898848	2016-04-12
Б.Ганболд	1692убн	Гандэлгэр	портр	ая1119410	2016-04-12
Т.Очирдарь	1224УБ	Амгалан	Daewoo solar	0311004	2016-04-12
А.Гарьдмагнай	7329дар	Бямбадорж	H.accent	0391801	2016-04-12
Д.Энхдэлгэр	8851убр	г.эрдэнэчулуун	h.eleanta	161196	2016-04-12
Н.Гэрэлмаа	86-82 уно	Б.Түмэнбаяр	T.Prius	0927	

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## Б.ЦЭРЭНПҮРЭВ: ТӨСВӨӨ НЭМЭХГҮЙ БОЛ ЗАМЫН КОМПАНИУД ДАМПУУРЧ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ЗОГСОНО

Монгол Улсад “ЛГБТИ” хүн 300 мянгаас илүү байна

Ц.СОЛОНГО

“ЛГБТИ” хүний эрхийн төрийн бус байгууллага болон Монгол Улс дахь Гёте-Институтийн төлөөлөгчийн газар хамтран “Тэгш эрх бахархалын өдрүүд”-ийг зохион байгуулахаар болжээ. Тус үйл ажиллагаа нь энэ сарын 26-аас есдүгээр сарын 04-ний өдрийг хүртэл үргэлжлэх бөгөөд “ЛГБТИ” хүмүүсийн эрх ашиг зөрчигдөж байгаатай холбоотойгоор мөн тэдний байр суурь, эрүүл мэнд, сэтгэлзүйн төвшин ямар байгааг илэрхийлэх зорилготой аж. “ЛГБТИ” гэдэг нь лесбиян, гей, бисексуал, трансжэндэр, транссексуал, интерсекс буюу нийтдээ бэлгийн цөөнхийг хэлэх дэлхий даяар хэлж нэршсэн нэр томъёо гэнэ. Үйл ажиллагаанд “Тэгш эрхийн төлөө ахалт”, “ЛГБТИ хүмүүс ба эрүүл оршихуй” хэлэлцүүлэг, “Миний найз ЛГБТ хүн” номын нээлт гэх зэрэг 10 өдрийн турш нийт 15 төрлийн арга хэмжээ багтсан байна. Монгол Улс болон өөр бусад орны хэмжээд “ЛГБТИ” хүмүүсийн тоог шууд судлах боломжгүй байдаг. Учир нь ЛГБТИ хүмүүс ихэнхдээ нууцлаг байдаг бөгөөд зарим нь бэлгийн чиг хандлагаа тодорхойлж чадаагүй байдаг байна. Бусад улсын нийт иргэдийн 10 хувь нь “ЛГБТИ” хүмүүс байдаг гэсэн судалгаанаас үзэхэд манай оронд ойролцоогоор 300 мянган иргэн байна. Түүнээс гадна бэлгийн чиг хандлага нь тодорхой биш иргэд хэд байгааг одоогоор мэдэхгүй байна гэдгээ ЛГБТ байгууллагын гүйцэтгэх захирал Н.Анараа хэлсэн юм.

Н.БАТЗАЯА

*Монголын автозамчдын үйлдвэрчний эвлэлийн холбооноос зам засварын төсвийн тодотголтой холбоотой асуудлаар хэвлэлийн бага хурал хийлээ. Энэ үеэр тус холбооны дарга Б.Цэрэнпүрэвээс зарим зүйлийг тодрууллаа.*

**-Зам засвар, арчилгааны мөнгийг танасан. Үүнээс болж хэчнээн компани алдагдал хүлээх болоод байна вэ?**

-Монгол Улсын хэмжээн дэх улсын чанартай замуудад засвар, арчлалтын ажлыг жил бүр хийдэг. Цас, бороонд элэгдэж, эвдэрсэн замыг арчилж, засвар хийх шаардлагатай байдаг. Тухайлбал, энэ жил бороо ихтэй зун байлаа. Борооны улмаас олон зам эвдэрсэн. Тэр болгоныг бид засч байна. Зам засварын арчлалт, засварын үйлчилгээ явуулдаг нийт 28 компанийн 1000 ажилчин бий. Авто замын салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг, замчдын эрхийг хамгаалах түрхорноос 2016 оны улсын чанартай авто зам засвар, арчлалтын ажилд 55 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн техник, эдийн засгийн үзүүлэлтийг үндэслэн төлөвлөсөн. Гэтэл төрөөс найман тэрбум төгрөгийг төсөвт суулган баталсан. Энэ мөнгөө нэмэгдүүлж өгөөч гэдэг шаардлагыг бид

...Энэ жил цас ихтэй өвөл болно. Харин тэр цасыг замчид яаж цэвэрлэх юм. Хүчтэй бороо, үерээс болж далангууд нурсан. Далан нурахад хэрэглэнэ гэж төлөвлөсөн мөнгө байхгүй. Ер нь ажлын байр бараг байхгүй боллоо. Хувийн хэвшлийн компаниуд бүгд өр, зээлтэй. Нийгмийн даатгал болон татварын газарт их хэмжээний өртэй болсон...

удаа дараа тавьсан. Авто зам арчлалтын ажилд төсөвлөсөн найман тэрбум төгрөг энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй 28 компанийн 1000 ажилчны цалинд ч хүрэхгүй. Танасан төсвийн хор уршгаас болж замын компаниудын үйл ажиллагаа удааширч улмаар өрийндарамгад орсон. Цалингаа ч тавьж чадахгүй болчихоод

байна шүү дээ. Автозамчид 180-300 мянган төгрөгийн цалинтай ажилладаг. Дөрвөн сарын цалингаа авч чадаагүй л байна. Мөн наймдугаар сараас эхлэн бүх арчлалтын компанийн ажилчид цалин хөлсгүй сул зогсож байгаа. Мянган хүн ажилгүй сул зогч байна. Үүний цаана мянган айл өрх ажилгүй болж байгаа гэсэн үг.

**-Зам ашигласны төлбөрийг саяхан нэмэгдүүлсэн шүү дээ. Тэр мөнгийг замын арчилгаанд зориулдаг гэж холбогдох албаныхан тайлбарлаж байсан?**

-Үгүй. Энд нэг том эндүүрэл яваад байгаа юм. Энэ жил зам ашигласны төлбөр, хураамж нэмэгдсэн. Тэр төлбөр нэмэгдсэнтэй холбогдуулан хүмүүс төлбөр хураах цэгийн ажилчидтай маргалдаж, бухимдаж байгаа. Зам ашигласны төлбөрөө нэмчихээд “Та нар замаа зассангүй” гэсэн байдлаар замчдыг дайрч, доромжилдог. Бүр замын төлбөр хураагчийг зодсон тохиолдол ч гарсан. Уг нь зам ашигласны төлбөр энэ зам арчлалттай ямар ч холбоогүй. Зам ашигласны төлбөр гэж жилд гурван тэрбум төгрөг улсын чанартай замд төсөвлөдөг. Харин орон нутгийн замд тухайн нутгийнхаа төсөвт ороод явдаг. Улсад зам ашигласны төлбөр гэж нийт 3-4 тэрбум төгрөг цуглардаг. Тэр мөнгөнөөс 20 хувийг л урсгал зардалдаа зориулдаг юм. Үлдсэн нь бүгд төрийн сан руу очдог. Гэтэл зам арчлалтын мөнгийг нэмсэн хэрнээ “Та нар замаа зассангүй” гэх буруу ойлголт иргэдийн дунд байна. Тийм биш юм. Тэгэхээр найман тэрбум төгрөгийг зарцуулаа гээд

бодоод үзье. Компани бүрт 200-300 сая төгрөг оногдоно. Нэг компанид 75-150 хүн ажилладаг. Тэгэхээр цалингийн сандаа ч хүрэхгүй байгаа биз. Ийм л мөнгө төсөвлөсөн. Бид удаа дараа шаардлага хүргүүлсний үр дүнд Засгийн газрын хуралдаанаар дэмжигдсэн гэдэг хариут Сангийн яамны холбогдох хүнээс амаар авлаа. Гэхдээ бичиг, цаас болоод нэмье гэсэн зүйл болоогүй байна. Энэ жил цас ихтэй өвөл болно. Харин тэр цасыг замчид яаж цэвэрлэх юм. Хүчтэй бороо, үерээс болж далангууд нурсан. Далан нурахад хэрэглэнэ гэж төлөвлөсөн мөнгө байхгүй. Ер нь ажлын байр бараг байхгүй боллоо. Хувийн хэвшлийн компаниуд бүгд өр, зээлтэй. Нийгмийн даатгал болон татварын газарт их хэмжээний өртэй болсон. Тиймээс энэ асуудлыг хурдан шийдвэрлэж, төсвөө нэмэх хэрэгтэй. Нэг бол бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох шаардлагатай. Тэр компаниуд хамгийн доод тал нь 28-38 жил ажилласан хүн бий. Тэдгээр ажилчдын нийгмийн асуудлыг яаж шийдэх юм бэ. Ажилчид л их хохирч байна. Одоо компаниудаас “Шагхуунаа зээлээр авъя” гэхээр “Замынханд өгөхгүй мөнгө байхгүй. Орж ирдэггүй юм чинь. Өгөхгүй” гэдэг болсон. Сүүлдээ ямар ч бүтээн байгуулалт хийх боломжгүй болсон. Бид хоёр зүйлийг хэлмээр байна. Нэгдүгээрт, төсвийн мөнгийг нэмэгдүүлэхийг хүсч байна. Хоёрдугаарт, зам ашигласны төлбөр замын арчлалтын компаниудад ямар ч хамаагүй гэдгийг иргэдэд ойлгуулахыг хүсч байгаа юм.

**“Гудамж” төслийн ажлыг гүйцэтгэсэн компаниудад санхүүжилтыг нь өгсөн гэсэн шүү дээ?**

-Үгүй. “Гудамж” төслийн ажлыг 22 компани гүйцэтгэсэн. Уг компаниудад 7.5 тэрбум төгрөг өгөх ёстой. Одоо болтол өгөөгүй. Бид хоёрдугаар сараас хойш шаардаж байна. 2015 оны төсөвт суугдсан ч энэ онд суугаагүй. Мөн “Гудамж” төслийн замын компаниуд бондын мөнгийг идсэн, уусан гэж яригдаж байгаа. Гэхдээ энд замчид огт хамаагүй. Бид улсын зарласан тендэрт шалгарсан. Тэдний хий гэсэн ажлыг л хийсэн. Биднийг хаанаас ч шалгасан хамаагүй. Харин хүнээр ажил хийлгэчихээд, хөлсийг нь өгөх хэрэгтэй биздээ. Биднийг нийт санхүүжилтийнхээ 90 хувийг авсан гэж гудамж төслөөс мэдээлсэн. Анх төлөвлөснөөр 200 сая төгрөг байсан. Тэрний 80 сая төгрөгийг нь хэрэглэсэн. Бусад нь улсын төсөвт орсон юм. Өөрсдөө төсөвлөж, хүмүүсээр зам хийлгэчихээд одоо болохоор мөнгөө өгөхгүй байна шүү дээ. Сая бүх замын компанийн концесс буюу эргэн төлөх нөхцөлтэйгээр төсвийг хаасан. Тэгэхээр ирэх жилээс замын компаниудын ажил зогсоно гэсэн үг. Хэдэн мянган хүн ажлын байргүй болно. Нэг компанийн асуудал яриагдаагүй байна. Хэдэн зуун мянган компани бий. Тусгай зөвшөөрөлтэй 500 мянган компани бий. Энд хүний эрх зөрчигдөж байна. хүмүүс амарч байхад замчид ажиллаж л байдаг. Наадмаар, АСЕМ-аар ч ажилласан. Тиймээс төсвийн мөнгийг нэмэх шаардлагатай байна.

PHOTO NEWS



Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос санаачилсан “1000 ЦУНХ challenge”-ын хаалтын ажиллагаа очигдөр Чингисийн талбайд боллоо. Энэхүү аян нь эдийн засгийн хүндрэлтэй өнөөгийн нөхцөлд ядуу бага орлоготой 1000 өрхийн төсөвт дэмжлэг үзүүлэх, тэдгээр өрхийн хүүхдүүдийн сурч боловсрох, эрдэм боловсрол эзэлших чин хүслийг төрүүлэх, урал зоригыг нэлэх, нийгмийн сайн сайхны төлөө хүмүүсийг нэгтгэн, зөргө санал санаачилгыг гэрээж, үр дүнг үзүүлэх зорилготой юм.

### 152 тарваганы махыг устгалд оруулжээ

Нийслэлийн Засаг даргын “Хүн, малын гоц халдварт өвчин, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” захирамж гарсан. Тус захирамжийн хүрээнд НМХГ бусад төрийн байгууллагуудтай хамтран таван дүүргийн найман товчоонд 24 цагийн хяналт шалгалт хийн ажиллаж байгаа юм. Шалгалт энэ сарын 1-нд эхэлсэн бөгөөд аравдугаар сарын 15-нд

дуусна. Өнөөдрийн байдлаар хөдөө орон нутгаас нийслэлд оруулж ирэхээр завдсан 152 тарваганы мах, түүхий тулмыг илрүүлж Зооноз өвчин судлалын үндэсний төвд хүлээлгэн өгч устгалд оруулжээ. Мөн хөдөө орон нутгаас гарал үүсэл нь тодорхойгүй, мал эмнэлгийн шинжилгээний бичиггүй амьтны гаралтай мах, түүхий эдийг илрүүлэн шалгаж байгаа аж.

### “Цагдаа хүн зодлоо” гэх худал мэдээлэл өгчээ

Баянгол дүүрэгт байрлах “...” ХХК-ийн засварчин 26 настай эрэгтэй Г ажлаа хийж байгаад гэмтжээ. Тодруулбал, Г нь автобусандаа засвар хийж байх үед тулгуур домократ нь мултарч улмаар цэвэжин хэсэг нь дарагдаж гэмтсэн байна. Тэрбээр, ГССҮТ-ийн хавсарсан гэмтлийн тасагт хэвтэн эмчлүүлж байгаа ажээ. Уг хэргийг Баянгол дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэс шалгаж байна. Мөн Баянзүрх дүүргийн “Сэнгүр горхи”

хотхоны манаачийн гэрт “Цагдаад зодуулж хөлөө хугалуулсан” гэсэн хүн ГССҮТ-өвд хэвтжээ. Уг хэргийг шалгахад тус дүүргийн 12 дугаар хороонд суух 57 настай эрэгтэй Т нь согтуурсан үедээ хугарсан байсан хөлөө “цагдаа зодож хөл хугалсан” гэж худал хэлсэн байна. Тиймээс түүнийг ЦАХ-ийг хүнд гэмт хэрэгт холбогдуулан худал мэдээлснийг Баянзүрх дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэст шалгаж байгаа аж.

### Сурагчдад цацруулагчтай ханцуйвч үнэгүй тараана

Улаабаатар хотын Замын цагдаагийн газар, Монголын сурагчдын холбоотой хамтран ЕБС-ийн бага болон дунд ангийн сурагчдад баруун гарын цацруулагчтай ханцуйвч өгөхөөр болжээ. Уг ханцуйвч нь сурагчдыг замын хөдөлгөөнд аюулгүй оролцоход туслах юм байна. Энэ талаар Замын Цагдаагийн газрын УСОНХХ-ийн цагдаагийн мэргэжилтэн, ахмад Я.Соронзонболд “Урьд нь хүүхдүүдийн цүнхэн дээр цацруулагч хийж өгсөн. Тэр цацруулагч зөвхөн орой гэрэлтэх үүрэгтэй. Харин баруун гарын цацруулагч нь өглөө, өдөр, шөнө гэрэлтдэг. Хүүхдүүд ханцуйвчаа баруун гартаа өмсч, замын хөдөлгөөнд

оролцоходоо баруун гараа өргөх юм. Ингэснээр өөрийн аюулгүй байдлыг хангана. Уг ажил “Хэрвээ би замын хөдөлгөөнд оролцоходоо баруун өргөж оролцохгүй бол жолооч надад зам тавьж өгөхгүй. Би зам тээврийн осолд өртөнө” гэдэг ухамсрыг л хүүхэд бүрт суулгах зорилготой” гэв. Энэхүү ажлыг сурагчдын дүрэмт хувцас үйлдвэрлэдэг “Батзүү”, “Шилмэл загвар”, “Төмөр трейд”, “Өүлэн менч” болон “Скайтел”, “Доктор авто сервис” зэрэг компаниудтай хамтран хэрэгжүүлэх гэнэ. Мөн эхний удаа 20-30 мянган ширхэг ханцуйвчийг үнэгүй олгох ажээ.

### Тусгай замын автобус төслийг эрчимжүүлнэ

Нийслэлийн Засаг дарга С.Батболд “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай” захирамж гаргасан байна. Захирамжаар нийслэлийн Засаг даргын тамгын газар, харьяа агентлагуудын бүтэц өөрчлөгдөн батлагдсангай холбогдуулан Тусгай замын автобус төслийг яаралтай, үр өгөөжтэй хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх 2012 оны наймдугаар сарын 23-ны өдрийн “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хуваарь 3-ын 2-т туссан хөтөлбөрийн

нийт хэрэгжилтийг хариуцагч, гүйцэтгэгч байгууллагын төслийн нэгж байгуулах, удирдан зохион байгуулалтаар хангах зэрэг үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг гүйцэтгэхийг “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” нийслэлийн өмчит хувьцаат компанид хариуцуулжээ. Энэхүү шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлж, Азийн хөгжлийн банкнаас зохих саналыг авч үр дүнг танилцуулахыг “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” нийслэлийн өмчит хувьцаат компанид захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга М.Отгонбаярт үүрэг болгожээ.

**ТАТАН БУУГДАВ**

Говь-Сүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж байсан 4612191 регистртэй Айсбеер ХХК, мөн Говь-Сүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж байсан 4612744 регистртэй МЭРВА ХХК татан буугдсаныг мэдэгдэж байна.

# ЗАВСАРЛАГА



Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр +22  
Шөнө +6

Нөгөөдөр  
Өдөр +24  
Шөнө +9



Аргын тооллын:  
2016 оны 08-р сарын 26,  
Баасан гараг

Билгийн тооллын:  
Налрын тэргүүн улаан  
бичин сарын шинийн 24.  
Гурван хөх лэнгэтэй Цагаан  
луу өдөр. Сугар гараг

Наран ургах/шингэх:  
07:05 / 20:46

Үс засуулбал:  
Өвчин элгээг ирнэ.



Тухайн өдөр худгана, бич жилтнээ аливаа үйлнийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, хөгжмийн шийтгэх, мал адгуус номхруулах, лус тахих, хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахна, гахайболой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

...Хэн чадаж байна, хэн амжилт гаргах магадлал өндөр байна, тийм тамирчныг, мэргэжлийн, мэргэшсэн багш, дасгалжуулагчийг сонгох ёстой болов уу. Риогийн олимпод ч шигшээ багийн алба алдаа гаргасан. Бид бус холбоо нь тамирчдаа сонгоод саналаа ирүүлээг юм хэмээн өөрсдийгөө өмөөрөх л байх...

# ИХ СПОРТОД УЛСТӨРЖИЛТ БУС ШИНЭЧЛЭЛ ХЭРЭГТЭЙ

Ч.ЧУЛУУН

Бразилийн Рио Де Женеиро хотноо зуны олимпын XXXI наадам өндөрлөд тав хонож байна. Дэлхийд алдраа дуурсгасан тамирчид нутаг нутгийн зүг мордож, эх орон нь амжилт гаргасан хүү, охиноо алга дэлгэн хүлээн авч хүндэтгэл үзүүлж буй энэ цаг үед Монгол Улсын тухайд алдаа, оноогоо хэлэлцэх ёстой санагдана. Олимпоос нэг мөнгө, нэг хүрэл медаль хүртсэн нь их юм гээд баг тамирчдад хариуцлага тооцохгүй өнгөрч болохгүй. Монголын төр олимпод оролцсон баг тамирчдыг чадлаараа дэмжсэн. Их спортод зөвхөн жүдо, чөлөөт, буудлага, бокс гэсэн дөрөвхөн төрөл байдаг юм шиг л байгаа жаахан төсвийнхөө 80 хувийг тэдний бэлтгэл сургуулид зарцуулж, боломжтой бүхий л улс оронд бэлтгэл сургуулийг нь хийлгэсэн. Хамгийн сүүлд Рио явахдаа хүртэл тусгай тогоочтой явж, олимпын хотонд бэлтгэл гарч, тэдний үйлчилгээнд зориулж автобус хүртэл захиалсан гэнэ лээ. Бусад спортын төрлийн тухайд ийм хангамж эдэлдэг гэж дуудлаагүй. Ингэж хэлэхээр дэлхийн улс орнуудын дэргэд монголчууд инээдтэй л гэх байх. Бэлтгэл сургуулийн нөхцлийн тухайд тиймхэн байж мэдэх ч заалны спортын хувьд хурдныхан шиг элдэв техник хэрэгсэл, бэлтгэлийн талбай шаардлагатай байдаггүй юм билээ. Заал, дэвжээ байхад л болоод явчихдаг аж. Цана тэшүүрийнхэн шиг дүн өвлийн хүйтнээр хөндийн жаварт иртүүзнээс өөр өмсгөлгүй бэлтгэл хийж, урагддаг бол аваргууд яах бол. Харин тэдэнд тэр бүр гадагшаа явж бэлтгэл хийх мөнгө олдоггүй, талбайн

гадна талд үлдсээр ирсэн байдаг. Ирэх өвөл Азийн тоглолт болно, 2018 онд өвлийн олимп болно. Цана тэшүүрийнхэн мөнөөх л Туул голоо тойрч цардмал зам дээргүйсхэн хэвээр. Эдүгээ улсын данс улайсан нөхцөлд тэдний бэлтгэл сургуулиг цааш яаж үргэлжлэхийг бурхан л мэдэх хэрэг байх. Өвлийн спортын битүү дээвэртэй ордонтой болох асуудал ирэх дөрвөн жилд лав лөөлөө болж байгаа сурагтай. Ирэх арваннэгдүгээр сараас дэлхийн цомын төлөөх цуврал тэмцээнүүд зохион байгуулагдана. Эрх биш яаж ийж байгаад нэгд нь ч болов явуулах л байх. Харин дээр дурдсан дөрвөн төрлийн хувьд дэлхийн хэмжээнд зохион байгуулагдсаар ирсэн уралдаан тэмцээнд явсаар оролцоор ирсэн. Аваргууд ч төрж байсныг үгүйсгэх аргагүй. Олимпын эрхийн төлөөх цуврал тэмцээнд оролцож эрхээ авах нь зүй ёсны хэдий ч олимпын дэвжээнд аваргын титмээ хамгаалж чадсангүй шүү дээ. Бөхийн орон хэмээгддэг атлаа Африкийн бөхийн мэхний аяст хөтлөгдөж байгаа хүнийг үндэсний шигшээ багийн тамирчин гэж хэлэхэд даанч харамсаар санагдсанг нуух юун. Дөрвөн удаа хөлдөө оруулж, алдчихаад ялагдаж байгаа тамирчинд байдгаа барьж, амжилт хүсч байсандаа уур хүрч сууна. Яах ч аргагүй нөхцлөөс ялагдаж буйг нь ойлгож хүлээж авах чадал монголчуудад бий. Түүнтэй ижил эрдэж бардаад ялагдаж буй тамирчинд хатуу сануулга өгөх эрх нь ч бас байх ёстой. Үнэнийг хэлэхэд, Монгол Улсын үндэсний шигшээ багийн тамирчдийг дасгалжуулагч нарын байгаа байдал нэг биш ээ. Спорт мэдэхгүй, спортоор хичээллэдэггүй хөндлөнгийн хүмүүст ингэж л харагдаж

байна. Спортын шинжлэх ухаан өдрөөс өдөрт хөгжиж буй энэ цаг үеийн хаагуур манай тамирчид явдаг юм бол. Гартаа, цээжиндээ бярттай бол хол явдаг байсан тэр үе эдүгээ хоцрогдсоныг дасгалжуулагч нар мэдэхгүй байна үгүй байлтай. Бярны цаана тархи нь сийрэг байж гэмээгээ амжилтад хүрдгийг дэлхийн олон тамирчин амжилтаараа бидэнд харуулсан, барилдаанаараа ч нотолсон. Энэ нь мэдээж тактик. Харин монголчуудад тактик алга. Дасгалжуулагч нар нь арай тактик хэрэггүй, бяраа гарга гэдэг юм биш байгаа. Нэгэн цагт бид Хятад, Солонгос, Японыг өвс идэж ус уудаг малтай жишдэг байлаа. Одоо эдгээр орны тамирчид дэлхийг амжилтаараа дагуулах боллоо. Тэдний амжилтад нууцсаад байх зүйл үгүй. Ердөө хувь хүний хичээл зүтгэл, сахилга бат, сэтгэлийн тэнхээ. Дээр нь багш дасгалжуулагч нар нь спортын шинжлэх ухааны ололт бүрийг нутагшуулж, өөрийн болгож чадаж буй байдал. Тамирчин, дасгалжуулагч хоёрын өөрийн болгох ёстой эдгээр хичээлийг үл тоосны гайг Риогийн олимп харуулаа. Шулуухан хэлэхэд, эдүгээ ажиллаж байгаа шигшээ багийн дасгалжуулагч нарын хэд нь номын дуу сонссон, мэргэжлийн дипломтой вэ гэх тухайд эргэж харах цаг болж. О.Балжинням аварга, З.Дувчин нарын тухайд өөрсдөө нэгэн цагт барилдаж явсан болохоос хүний биеийн бүтцийг нарийн судалж, спортын шинжлэх ухааны ололтыг монгол хүний, монгол тамирчны биеийн онцлогт хэрхэн нөлөөлж болохыг мэдэх дасгалжуулагч нар мөн эсэх нь эргэлзээтэй. Нөгөөтэйгүүр, энэ салбарын гал тогоог алсын зайнаас улстөрчид удирдаад ирэхээр юу

бодогийг нь бид харж сууна. Төр солигдох бүрийд эрх барьж буй нам нь өөрийн хүнээ спортын салбарт тавьдаг. Өнөөх нь ирсэн даруйдаа өөрийн хүмүүсээр баг бүрдүүлж бужигнуулааг нь нууц биш. Риогийн олимпын наадам эхлэхэд хэдхэн сар дутуу байхад Спорт хөгжлийн төвийн даргаар Д.Жаргалсайхан гэх нөхрийг МАХН зүтгүүлсээр байгаад тавьсан. Өнөөх нь тамирчдын бэлтгэл сургуулид анхаарал хандуулахын оронд газар, хэлтсийн дарга нараа сольж, өөрөө боломж олдсон дээр нь гэсэн шиг дэлхийгээр хэссээр таарсан. Хамгийн сүүлд яв, мордохын хазгай гэгчээр олимпод оролцох тамирчдын авч явах чөмөдэн дээр ажиллаж, багагүй мөнгө дундаас нь унагаж хөгөө хөлдөө чирсэн. Хийсэн хэргээ шигшээ багийн албаны дарга руугаа чихэж орхисон байна лээ, Facebook хуудсаараа дамжуулаад. Ер нь тэгээд дэлхийн чанартай томоохон тэмцээн хаана болно тэнд Хөгжлийн төвийн ажилтан албан хаагчид онц ач холбогдолгүй мөртөө тамирчдын суганд хавчуулагдаад очсон байдгаа өнөөдрөөс болих хэрэгтэй. Тэдний ниссэн онгоцны зардал, буудлын мөнгийг бусдад нь өгье л дөө. Тамирчид ингэж гомдол мэдүүлж байхыг олонтоо сонссон хүний хувьд агентлагийн шинэ удирдлагууд онцгой анхаарах биз ээ. Энэ бол улстөрийн албан тушаалтнууд спортын салбарт шургасны гай. Тэгээд ч мэргэжлийн, мэргэшсэн боловсон хүчин шаарддаг энэ салбарт улс төрийн намууд, улс төрчид хуруу дүрэх нь илүүц юм. Алдааг нь нам хүлээхгүй, тамирчид буруудаад үлддэг гэдгийг хаа хаанаа ухаарх цаг болжээ. Бас нэг хөндөх сэдэв бол тамирчны сонгон

шалгаруулалт. Үндэсний шигшээ багийн сонгон шалгаруулалтад сүүлийн жилүүдэд улс төрчид ямар нэг байдлаар нөлөөлсөөр ирсэн гэж дууддаг. Монголын нэрийг дэлхийд гаргах тамирчин, тэднийг дасгалжуулах багш, дасгалжуулагч нарыг сонгон шалгаруулахад нутаг нуга, танил тал ерөөсөө хамаа байхгүй. Хэн чадаж байна, хэн амжилт гаргах магадлал өндөр байна, тийм тамирчныг, мэргэжлийн, мэргэшсэн багш, дасгалжуулагчийг сонгох ёстой болов уу. Риогийн олимпод ч шигшээ багийн алба алдаа гаргасан. Бид бус холбоо нь тамирчдаа сонгоод саналаа ирүүлдэг юм хэмээн өөрсдийгөө өмөөрөх л байх. Юун төлөө шигшээ багийн алба гэж байгаа билээ, тамирчин нэг бүрийн амжилтад судлагдаахийг, амжилт нь ахиаж явааг сонгох учиртай бус уу. Олимпын үеэр жүдо гэхэд л Д.Амартүвшин, чөлөөт бөхийн төрөлд Д.Орхоны оронд С.Цэрэнчимэдийг явуулдаг байж хэмээн өнөөдөр амаа барьцгааж сууна. Энэ бүхэн миний дээр өгүүлсэн тамирчдын сонгон шалгаруулалт но-той явж ирсний жишээ юм. Эцэст нь хэлэхэд, их спортод ялт ч үгүй өөрчлөлт хэрэгтэй байна. Тэрхүү өөрчлөлтийг шинээр байгуулагдсан агентлагийн дарга Ц.Шаравжамц хийх биз ээ. Туршлагагүй хэмээцгээн өө хайх л юм. Тэр залуу хүн. Цагтаа спортод сэтгэл оюунаа зориулж явсан хүнийхээ хувьд хэдийнэ салбарынхаа хөгжлийн загвар, чиг хандлагыг тодорхойлсон нь дамжиггүй. Түүний хэр ажиллаж буйг ирэх өвлийн Азийн тоглолт, 2018 оны Пинчэний өвлийн олимп тэртээ тэргүй харуулна шүү дээ.

**ТЭНГИС**  
КИНО ТЕАТР

Нэгэн залуу хайр дурлалынхаа төлөө өглөө бүр хийдэг дадал зуршил болсон гэнэтийнхээ бэлгийг хайртай охиндоо барьснаар киноны үйл явдал эхэлнэ. Үүнээс үүдэж өөр хайр дурлалтай учирна. Энэ хайр дурлалыг нь хоёр найз нь эсэргүүцэж киноны үйл явдлыг өрнүүлж асуудлыг улам хурцдуулна.

УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ